

**УЛС ТӨР**

Д.БАЯРМАА: ШИНЭЧИЛСЭН ЖУРМААР БИЧИЛ УУРХАЙЧИД 3500 СМ<sup>3</sup> ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ АШИГЛАХААР ЗОХИЦУУЛСАН

II нүүрт

**СОНГУУЛЬ-2017**

ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛИЙН ЭРГЭН ТОЙРОНД...

IV-V нүүрт

Улаанбаатар: ӨНӨӨДӨР



Дугаарын **60** мөр  
Даатгалынхныг  
өөгшүүлж болохгүй  
ч.чулуун

## ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛИЙН ЭХНИЙ ШАТАНД Х.БАТТУЛГА ТАСАРХАЙ ЯЛЛАА

ОНЦЛОХ МЭДЭЭ

Гурван өдөр архи зарахгүй

Ерөнхийлөгчийн сонгуультай холбоотойгоор Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Багболд Сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай захирамж гаргаж, өнөөдрийн 00.00 цагаас 28-ны өдрийн 00.00 цаг хүртэл нийслэлийн нутаг дэвсгэрт архи, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг түр хориглох шийдвэр гаргасан билээ. Мөн нийтийг хамарсан үйл ажиллагаа явуулахыг хориглох заалттай учраас энэ сарын 25-нд болох байсан "Яг түүн шиг" шоуны хаалтын тоглолтыг цуцлаад байгаа юм.

Мөн их Жанжин Д.Сүхбаатарын талбайд ч нийтийг хамарсан үйл ажиллагаа, урлаг соёлын тоглолт явуулахгүй байхаар захирамждаа тусгажээ. Ерөнхийлөгчийн сонгууль өгч буй энэ өдөр бүх нийтийн амралтын өдөр учраас дугаарын хязгааралт үйлчлэхгүй, мөн томоохон зах худалдааны төвүүд ч амарлаа.



Үргэлжлэл нь III нүүрт

Гэрэл зургийг Т.АРТУУЖИН

Монгол Улсад эдүгээ эрдэл үүрэггүйгээр ашиг олж байгаа салбар бол даатгал. Энэ салбар хувийн хэвшил рүү шилжсэнээр байшингийн булан тохой бүрт даатгалын компаниуд байгуулагдсан. Борооны дараахь мөөг шиг л. Даатгалын тухай хууль 1997 онд шинээр батлагдахад ердөө өсөн аж ахуйн нэгж Сангийн сайдаас үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан байдаг бол эдүгээ энэ тоо 26 болсон байх жишээтэй. Тэр үед даатгалын компанийн дүрмийн сан 100 сая төгрөг байсан бол өдгөө ердийн даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээ тав, урт хугацааны буюу амьдралын даатгалын компанид зурга, давхар даатгалынх 15 тэрбум төгрөг болж өсчээ. Эл тоон үзүүлэлтээс тус салбар тавигдах шаардлага өндөрсөнөөг харахаас илүүтэй мөнгөтэй хүний эрхэлдэг бизнес гэдгийг анзаарч болно.

Үргэлжлэл нь II нүүрт

МОНГОЛ ДЭЛХИЙН ХЭВЛЭЛД

### ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛЬ ДЭЛХИЙН СОНОРТ БАЙЛАА



Б.ДАВААХУУ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн долоо дахь удаагийн сонгууль болж, монголчууд тав дахь Ерөнхийлөгчөө өчигдөр сонголоо. Чингис хааны төрсөн нутаг гэдгээрээ дэлхий дахинаа танигдаж, байгалийн баялгийн арвин нөөцөөрөө гадаадын хөрөнгө оруулагчдын анхаарлыг татдаг Монгол Улсын төрийн тэргүүний сонгууль ч олон улсын хэвлэл мэдээллийн анхаарлын төвд байв. Тэр дундаа Японы томоохон хэвлэлүүд манай улсын Ерөнхийлөгчийн сонгуулийг анхааралтай ажиглаж, өөр өөрийн өнцгөөс мэдээллийг хүргэж байсан билээ. Ингээд бид "Монгол дэлхийн хэвлэлд" буландаа гадны хэвлэлүүдэд сонгуулийн талаарх мэдээлэл хэрхэн нийтлэгдсэнийг уншигчиддаа хүргэж байна.

Үргэлжлэл нь VI нүүрт

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

### Хөвсгөл аймгийн Их-Уул суманд ХУУРАЙ СҮҮНИЙ ҮЙЛДВЭР НЭЭЛТЭЭ ХИЙВ

Б.БАЯР

Засгийн газар, Хүнсхөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн яамнаас "Эрүүл хүнс-Эрүүл монгол хүн" зорилт тавьж, энэ хүрээнд "Мах сүүний анхдугаар аян"-ыг 2017 оны нэгдүгээр сарны 01-ээс өрнүүлж эхэлсэн. Аяны хүрээнд аллагдсан аймаг, сумдад хөдөө аж ахуйн боломжит нөөцөө бүрэн ашиглах, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж олон улсын стандартад нийцсэн бүтээгдэхүүн, түүхий эдийг экспортод тогтвортой нийлүүлэх боломжийг бий болгохоор хуурай сүүний зөөврийн үйлдвэрийн төслийг хэрэгжүүлж эхэлсэн. Тодруулбал, "МДМ" ХХК сүү хуурайшуулах үйлдвэрийн төслийг санаачилж, 19 аймгийн 60 суманд өдөрт 1.5 тонн шингэн сүү хуурайшуулах хүчин чадалтай үйлдвэрүүдийг байгуулахаар болсон. Энэхүү төслийн эхлэл болж Хөвсгөл аймгийн Их-Уул суманд эхний

жишиг үйлдвэр ашиглалтад орж нээлтээ өнгөрөгч бямба гарагт хийлээ. Тус үйлдвэр нь нэг цагт 80 литр шингэн сүү боловсруулах хүчин чадалтай бөгөөд хүний нөөцийг сургах тоног төхөөрөмжийг суурилуулах ажлууд давхар хийгдэж байна. Мөн төслийн хүрээнд нийт 1000-2000 тогтмол ажлын байр шинээр бий болж 20 гаруй мянган малчин өрхөөс түүхий эд хүлээн авч малчдын орлого нэмэгдэх юм.

Үргэлжлэл нь II нүүрт

# МОНГОЛЫН МЭДЭЭ

19 ДЭХ ЖИЛЭЭ

## Манай сонины III улирлын захиалга үргэлжилж байна

Улирал **44** дугаар

### Захиалгын үнэ 19800

Монгол шуудан: 70078977  
УБ шуудан: 70127027  
Скай пост: 70121294  
Түгээмэл шуудан: 70115025

ХААН банк				Худалгаа хөгжлийн банк				
	Авах	Зарах		Авах	Зарах		Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2345.00	2359.00	ФУНТ	2945.00	3036.00	АМ.ДОЛЛАР	2345.00	2359.00
ЕВРО	2605.00	2659.00	РУБЛЬ	38.70	40.60	ЕВРО	2572.00	2674.00
ИЕН	20.98	21.32	ЮАНЬ	342.00	345.70	ИЕН	20.67	21.57
						ФУНТ	2932.00	3047.00
						РУБЛЬ	37.49	42.26
						ЮАНЬ	342.00	346.40

Өчигдрийн 19.00 цагийн байдлаар

# УЛС ТӨР

МЭРГЭЖИЛТНИЙ ҮГ

## Д.БАЯРМАА: ШИНЭЧИЛСЭН ЖУРМААР БИЧИЛ УУРХАЙЧИД 3500 см<sup>3</sup> ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ АШИГЛАХААР ЗОХИЦУУЛСАН

Н.БАТЗАЯА

*Өнгөрсөн тавдугаар сард Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмыг шинэчлэн баталсан билээ. Үүнтэй холбогдуулан "Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоо"-ны гүйцэтгэх захирал Д.Баярмаатай ярилцлаа.*

-Юуны өмнө "Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоо"-ны талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөхгүй юу. Танай холбоонд одоогийн байдлаар хэчнээн бичил уурхайчид бүртгэлтэй байна вэ?

"Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоо" 2013 оны тавдугаар сарын 2-нд байгуулагдснаас хойш орон нутагт бичил уурхайн үйл ажиллагаа явуулж буй гишүүдийнхээ эрх ашгийг хамгаалах, бодлого боловсруулахад тэдний дуу хоолойг хүргэх, хариуцлагатай бичил уурхайн талаар олон нийтэд эерэг ойлголт өгөх зэргээр үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулж байна. 1990-ээд оны сүүл, 2000 оны эхээр улс орон зах зээлийн нийгэмд шилжихэд улсын үйлдвэрүүд хаалгаа барьж, үйлдвэрийн олон ажилчин ажилгүй, орлогогүй болж хоцорсон. Тухайн үед ажилгүйдлийн тоо огцом нэмэгдсэн. Мөн 2000-аад оны эхээр улсын хэмжээнд жил дараалсан хүндэн зуд турхан болж, олон малчид амьжиргааны эх үүсвэр болсон малаа алдсан. Эдгээр шалтгаануудын улмаас гэр бүл, үр хүүхдээ гэжээж, амьжиргаагаа залуулах гэсэн иргэд хувиараа ашигт малтмал олборлох эхэлсэн байдаг. Тэдгээр иргэд нь хүмүүсийн

хэлж заншсанаар "нинжа" нар. Сүүлийн үед "нинжа" нарыг хувиараа ашигт малтмал олборлогч буюу "ХАМО" иргэд гэж нэрлэж байна. "ХАМО" болон "бичил уурхай эрхлэгчид" маш их ялгаатай. Бичил уурхайчид бол холбогдох хууль журмын хүрээнд зохион байгуулалтад орж, тухайн сумынхаа Засаг даргатай гэрээ байгуулан, албн ёсоор дүгнэлт нь гарсан газар аюулгүй байдлаа хангаж ажиллаж байгаа хүмүүсийг хэлнэ. Мөн тухайн газартаа олборлолт явуулахад, нөхөн сэргээлтээ өөрсдөө

...Бичил уурхайгаар олборлож буй алтны нийлүүлэлтийн сүлжээг албажуулах талаар анхаарах цаг болсон. Энэ талаар төр засаг анхааралдаа авч холбогдох бодлого, хөтөлбөртөө оруулж эхэлсэн байна. Алтаа сорьцуулахын тулд бичил уурхайчид заавал Улаанбаатар хотноо ирэх хэрэгтэй болж байгаа юм. Учир нь Монгол банк зөвхөн Үнэт метал, сорьцын хяналтын газраар сорьцуулсан алт авдаг...

хийн буцааж хүлээлгэн өгдөг. Хариуцлагатай бичил уурхайчдын талаар олон сайн туршлага бий болоод байна. Манай "Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоо" (МБУНДХ) нь өөрийн сургагч багш нартай ба сургагч багш нараараа дамжуулан гишүүн бичил уурхайчиддаа үйлчилгээ үзүүлэхээс гадна ХАМО иргэдийг зохион байгуулалтад оруулах, албажуулах талаар тэдэнд хүрч ажиллаж байна. Өнгөрсөн 2016 оны хувьд бид бүхэн нийт 4000 гаруй ХАМО иргэдэд хүрч сургалт явуулан, холбогдох мэдээ, мэдээллийг

өгсөн. Одоогийн байдлаар манай дээвэр холбоонд гишүүнчлэлтэй 15 аймгийн 45 сумын 69 бичил уурхайн байгууллагын 6000 гаруй бичил уурхайчин байдаг. Манай дээвэр холбооны гишүүдийн тоо жил ирэх тусам нэмэгдэж байгаа.

-Өнгөрсөн тавдугаар сард Засгийн газрын 151 дүгээр тогтоолоор Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам шинэчлэгдэн батлагдлаа. Энэхүү журам бичил уурхайчдын үйл ажиллагаанд хэр өгөөжтэй журам болов?

"Маш их өгөөжтэй журам батлагдлаа гэж бичил уурхайчид харж байна. Учир нь тус журмын өөрчлөлтөд бичил уурхайчдынхаа саналыг авч манай МБУНДХ-оос холбогдох төрийн байгууллагуудад хүргэж ажиллаж ирсэн. Бичил уурхайчдын саналын шинэчлэгдсэн журманд орж батлагдлаа. Уул уурхай хүнд үйлдвэрийн яаман дээр байгуулагдсан журмыг шинэчлэн сайжруулах ажлын хэсэгт бичил уурхайчдын төлөөллийг оруулан бидэнд өөрсдийн санал бодлоо хуваалцаж нөхцөл байдлаа ойлгуулахад эмхэтгэж ажилласан бүх байгууллага, хүмүүстэй байрласнаа илэрхийлж байна. Үүнийг бичил уурхайчдын төлөөллийг оруулан бидэнд өөрсдийн санал бодлоо хуваалцаж нөхцөл байдлаа ойлгуулахад эмхэтгэж ажилласан бүх байгууллага, хүмүүстэй байрласнаа илэрхийлж байна. Үүнийг бичил уурхайчид бид маш том амжилт гэж харж байна. Одоо бид өөрсдөө журмын хүрээнд үйл ажиллагаагаа улам хариуцлагажуулж ажиллах ёстой. Шинэчлэгдэн батлагдсан энэхүү журмын хүрээнд бичил уурхай эрхлэгч этгээд нь Иргэний хуулийн 35.1-д заасан нөхөрлөл, 36.4-т заасан хоршооны хэлбэрээр зохион байгуулагдсан хуулийн этгээд, мөн хуулийн 481.1-д заасан бүртгэгдээгүй нөхөрлөлийн хэлбэртэй байна гэсэн байгаа. Хоршоо болон нөхөрлөлийн зохион байгуулалтад орж хуулийн этгээд болсноор өөр төрлийн бизнес эрхлэх, санхүүгийн байгууллагатай харилцах зэрэг давуу талууд нэмэгдэж байгаа юм. Мөн бүртгэгдээгүй нөхөрлөл нь өмнө нь таваас доошгүй хүний бүрдэхүүнтэйгээр байгуулагддаг байсан бол энэ шинэчлэгдсэн журмаараа есөөс доошгүй хүн байгуулдаг болсон нь мөн нэг давуу тал болоод байна. Бичил уурхайчдын хамгийн ихээр талархан хүлээн авч байгаа нэг өөрчлөлт бол бичил уурхайд ашиглагдах тоног төхөөрөмжийн хүчин чадал долоо дахин нэмэгдсэн явдал юм. Бичил уурхайд ашиглах тоног төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх талаар бичил уурхайчид маань олон жил ярьж, саналаа холбогдох байгууллагуудад хүргэж ирсэн. Өмнө нь 500 см<sup>3</sup> багтаамжтай дотоод шаталтат хөдөлгүүр бүхий тоног төхөөрөмж ашигладаг байсан. Харин одоо



шинэчлэгдсэн журмын хүрээнд нөхөрлөл, хоршооны зохион байгуулалтад орсон бичил уурхай эрхлэгч хуулийн этгээд нь ашигт малтмал олборлохдоо 3500 см<sup>3</sup> хүртэлх багтаамжтай дотоод шаталтат хөдөлгүүр бүхий хоёроос доошгүй механизмыг ашиглах боломжтой боллоо. Бичил уурхай эрхлэгчдийнхээ хувийн хэргээр хууль бичил уурхайчдын саналыг тусгасан, эрх ашгийг хүндэлсэн хэд хэдэн заалтууд орсон шинэчлэгдсэн журам батлагдсанд бид бүхэн маш их баяртай байна. Түүнчлэн өмнө нь тухайн сумынхаа Засаг даргаар уламжлан бичил уурхайн зориулалтаар газар авах хүсэлтээ бүртгэгдээгүй нөхөрлөлийн гишүүд Ашигт малтмал, газрын тосны газарт явуулдаг байсан. Одоогийн шинэчлэгдсэн журмаар тухайн орон нутагт зохион байгуулалтад орсон (дээр дурьдсанчлан бүртгэгдээгүй нөхөрлөл, нөхөрлөл, хоршоо) бичил уурхайчид саналаа сумын Засаг даргаар дамжуулан аймгийн Засаг даргад хүсэлтээ зориулдаг. Тухайн аймгийн Засаг дарга бичил уурхайн зориулалтаар ашиглах газрын хүсэлтээ холбогдох дагалдах материалуудын хамт Ашигт малтмал, газрын тосны газарт хүргүүлнэ. Хэрэв АМГТ-аас боломжтой гэсэн дүгнэлт гарвал, уг дүгнэлтийг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцэн ажлын 10 хоногийн дотор шийдвэр гаргадаг болсон. Үүний дараагаар орон нутагт байгаа зохион байгуулалтад орсон бичил уурхайчидтайг эрхлэгчид нэртэй тухайн газрын бичил уурхайн зориулалтаар ашиглах боломж бүрдэнэ. Бичил уурхайд хариуцлагын тогтолцоо их чухал. Үүнийг ч гэсэн шинэ журамдаа тусгасан байна лээ. Хэрвээ та хууль, журмын хүрээнд бичил уурхайгаар ашигт малтмал олборлож байгаа л бол тухайн орон нутгийнхаа эдийн засагт хувь нэмрээ оруулж татвараа төлөх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн байдлаа хангаж ажиллах, олборлосон газраа эргээд нөхөн сэргээх зэргийг хариуцлагатайгаар хийх л хэрэгтэй.

гэлээ. Үүнээс болж хуулийн дагуу бичил уурхайгаар ашигт малтмал олборлогчдын үйл ажиллагаанд саад учруулсан тохиолдол байдаг уу.

"Тийм тохиолдол олон бий. Ер нь хаана алт гарна, тэр сургаар тухайн газарт бөөгнөрөл үүсэх нь элбэг. Хэн бөөгнөрөл үүсгэж байна вэ гэвэл өмнө нь миний хэлсэнчлэн нөгөө зохион байгуулалтад ороогүй, хаа дуртай газраа ухаж явдаг, эргээд нөхөн сэргээлтэй хийдэггүй нинжа буюу ХАМО иргэд ихэнхдээ байдаг. Тэдгээр ХАМО иргэдийн хариуцлагагүй, хууль бус үйл ажиллагаа нь холбогдох хууль журмын хүрээнд тухайн нэг газартаа тогтвортой үйл ажиллагаа явуулж буй бичил уурхайчдыг буруугаар ойлгоход нөлөөлдөг. Тиймээс бөөгнөрөл үүссэн газарт төр өөрөө хяналтын механизмаа чангатгах хэрэгтэй. Ирэх долдугаар сарын 1-нээс хэрэгжих эхлэх Зөрчлийн тухай хуулийн 6.11 дүгээр зүйлийн 5 дахь заалтад "Бичил уурхайгаар ашигт малтмал олборлохтой холбогдсон харилцааг зохицуулах талаар тогтоосон журмыг зөрчсөн бол хүнийг далан таван нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг долоон зуун таван нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно" гэж заасан байна. Миний хувьд бичил уурхайчид ч гэсэн өөрсдөө бас хариуцлагатай үйл ажиллагаа явуулах ёстой. Ер нь хаана хаанаа хариуцлагын тогтолцоог л сайжруулах хэрэгтэй байгаа юм.

-Байгаль орчны нөхөн сэргээлтийн ажлыг хийх шаардлагатай гэлээ. Бичил уурхайчид нөхөн сэргээлтийн ажлыг хэр гүйцэтгэдэг вэ?

"Манай МБУНДХ нь Швейцарийн хөгжлийн агентлагаас санхүүжүүлж Азийн сангаас хэрэгжүүлсэн "Байгаль орчныг хамгаалахад талуудын оролцоог бэхжүүлэх нь II" төсөлтийг хамтран ажилласан. Тус төслийн хүрээнд манай дээвэр холбооны гишүүн 10-аад бичил уурхайчид өртөг багатай аргачлалаар нөхөн сэргээлт хийх талаар сургагч багшаар бэлтгэгдсэн. Бэлтгэгдсэн сургагч багш нар маань орон нутагт бичил

уурхайчиддаа сургалт зохион байгуулсан. Аргачлалынхаа дагуу бичил уурхай эрхлэгчид 210 га талбайд нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэлээ. Техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийж, тухайн орон нутагтаа хүлээлгэн өгсөн. Гэхдээ манай бичил уурхайчдын нөхөн сэргээлт хийн хүлээлгэж өгсөн газарт хууль бусаар компани, хувь хүмүүс дайрч орох асуудлууд нэдээдгүй гарч байлаа. Дээвэр холбооны зүгээс тухайн үед хэвлэлийн бага хурал хийж, хууль бус үйлдлийг таслан зогсоож байсан.

-Сорьцын асуудлаас болж бичил уурхайчид ченжүүдээр дамжуулж олборлосон алтаа Монголбанкинд өгдөг. Уг асуудлыг шийдэх ямар боломж байна вэ?

"Монголбанкны эрдэнэсийн санд олборлосон алтаа шууд тушаах механизмыг бүрдүүлж байна. 2016 онд улсын хэмжээнд Монголбанкинд 18.3 тонн алт тушаасан байдаг. Түүний 10.3 тонныг иргэд тушаасан юм билээ. Харин иргэдийн ихэнх хувийг бичил уурхай эрхлэгчид эзэлж байгаа шүү дээ. Өөрийн чинь хэлсэнчлэн ченжүүдээр дамжуулан Монголбанкинд алтаа тушаадаг байдлыг өөрчлөх хэрэгтэй байгаа юм. Энэ асуудал бол бичил уурхайчдын хувьд нэн тэргүүнд тулгарч буй асуудлуудын нэг. Бичил уурхайгаар олборлож буй алтны нийлүүлэлтийн сүлжээг албажуулах талаар анхаарах цаг болсон. Энэ талаар төр засаг анхааралдаа авч холбогдох бодлого, хөтөлбөртөө оруулж эхэлсэн байна. Алтаа сорьцуулахын тулд бичил уурхайчид заавал Улаанбаатар хотноо ирэх хэрэгтэй болж байгаа юм. Учир нь Монгол банк зөвхөн Үнэт метал, сорьцын хяналтын газраар сорьцуулсан алт авдаг. Тэр байгууллага маань зөвхөн Улаанбаатар хотод байдаг. Иймд алт сорьцох албан ёсны газруудыг орон нутагт эхний ээлжинд бүсчилсэн байдлаар байгуулах нь зүйтэй болов уу. Мөн хаана аль аймагт олон бичил уурхайчид үйл ажиллагаа явуулж байна гэдгийг бас харгалзан үзэх байх л даа.

### ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

## ХӨВСГӨЛ АЙМГИЙН ИХ-УУЛ СУМАНД ХУУРАЙ СҮҮНИЙ ҮЙЛДВЭР НЭЭЛТЭЭ ХИЙВ



Төгсгөл. Түрүүч нь I нүүрт

Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны ХШУДАГ-ын дарга У.Ц.Совд "Орон нутагт ашиглагдахгүй байгаа сүүний нөөцийг ашиглах, хүн амын сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангах, импортыг орлох, улмаар экспортыг нэмэгдүүлэх бодит шаардлага тулгараад байна. Эдгээр шаардлагад нийцүүлэн сүүний салбарыг хөгжүүлэхэд төр, хувийн хэвшлийн түншлэл, хамтын ажиллагаа, хувийн хэвшлийн идэвхи санаачилга, орон нутгийн бодит оролцоо чухал ач холбогдолтой. Аяны хүрээнд орон нутагт ашиглагдахгүй байгаа сүүний нөөцийг ашиглах, хуурай сүүний импортыг орлох, экспортод чиглэсэн дотоодын үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилгоор "Монгол драй милк" ХХК-тай хамтран "Монгол хуурай сүү"



төслийг хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд 21 аймагт хуурай сүүний бага, дунд оврын үйлдвэрүүдийг үе шаттай байгуулах их ажлын шанг татаж Хөвсгөл аймгийн Их-Уул суманд жиншиг үйлдвэрийн нээлтийг өнөөдөр хийж байна "гэдгийг тэрбээр онцлов. "Монгол

драй милк" ХХК-ий захирал Э.Эрдэнэбилэг "Сүү хуурайшуулах үйлдвэрийн төсөл 2017-2025 он хүртэл 8 жилийн хугацаанд бүрэн хэрэгжинэ гэж үзэж байна. 2017 онд 19 аймгийн 60 сумдад өдөрт 1.5 тонн шингэн сүүг хуурайшуулах хүчин чадалтай үйлдвэрүүдийг байгуулж орон

нутаг, цаашлаад улс орны хөгжилд хувь нэмрээ оруулна. Сүүг хуурайшуулах нь тээвэрлэлтийн зардлыг 10 дахин хэмнэхээс гадна жилийн дөрвөн улиралд хадгалах боломжийг бүрдүүлж дотоодын сүү үйлдвэрлэлийг түүхийн эдээр хангах ач холбогдолтой" гэж нээлтийн үеэр хэлж байв.

# ҮЗЭЛ БОДОЛ

Дугаарын **60** мөр

## Даатгалынхныг өөгшүүлж болохгүй

Үргэлжлэл.  
Түрүүч нь I нүүрт

Нөгөөтэйгүүр, даатгалын хураамжийн хэмжээ зах зээл дэх эрэлтээ дагаад байнга нэмэгджээ. Жишээ нь, 2009 онд даатгалын хураамж 15 хувь байсан бол 2012 оноос 60 гаруй хувь болж өссөн байх жишээтэй. Нөгөөтэйгүүр, даатгалынхан юунаас ашиг унагаахаа маш сайн мэддэг. Иргэдийн амь нас, эрүүл мэнд, эд хогшил, орон сууц, агаарын хөлтөөр зорчсон тохиолдол бүрт авах амь насны даатгал тэр чигээрээ компанийн ашиг болдог байна. Дээр нь Жолоочийн хариуцлагын даатгал, тээврийн хэрэгслийн албан журмын даатгалыг нэрлэж болно. Тээврийн хэрэгслийн тоо нэмэгдэхийн хэрээр компанийн эздийн халаас түнтийдэг. Тодруулбал, даатгалын компануд хураамжийн 100 төгрөг тутмын 43 төгрөгийг нөхөн төлбөр, ажилчдын цалин нийгмийн даатгал, татвар болон бусад зардалд төсөвлөж, үлдсэн 57 төгрөгийг цэвэр ашиг гэж үздэг байна. Өнгөрсөн жилийн байдлаар 540 мянган иргэн тээврийн хэрэгслийн болон жолоочийн хариуцлагын даатгалд хамрагдаж, тэднээс 31 мянган иргэн нөхөн олговор авсан байна. Харин иргэдийн даатгалын талаархи ойлголт Жолоочийн хариуцлагын даатгал төдийнхөөр хэмжигдэг нь нууц биш. Амь нас, эрүүл мэндээ даатгасан иргэдээс эрүүл мэндийн даатгалд хамрагдсан иргэдийн дөнгөж найман хувь нь л нөхөн төлбөрөө авчээ. Энэ нь өөрийн зардалаар хилийн чинадад мэс засал хийлгэсэн иргэд эх орондоо эргэж ирсэн хойноо гаргасан зардлынхаа 30 хувийг эргүүлж авсан үзүүлэлт. Дашрамд өгүүлэхэд, ийм тохиолдлын нөхөн төлбөр барагтай л бол тухайн жилдээ багтаж олгогддоггүй гэдгийг хэлэх нь зөв байх. Харин жолоочийн хариуцлагын болон тээврийн хэрэгслийн даатгалд хамрагдсан иргэд завтай болоод хөөцөлдлөгөө сайтай бол сарын дотор нөхөн олговроо олж авч чаддаг. Жолоочийн хариуцлагын тухай хууль хэрэгжиж эхэлснээр тээврийн хэрэгсэл эзэмшигч хүн бүр албан журмаар даатгалд /Жилийн хураамж тээврийн хэрэгслийн машин, үйлдвэрлэгдсэн оноос хамаарч 33 мянган төгрөг/ хамрагдах болсон. Харамсалтай сайн дураараа биш албан хүчээр даатгуулж буй. Даатгалаа хийлгээгүй жолоочийг Замын цагдаа зогсоон торгодог. Эл үйлдэл цаад угтаараа төр мөнгөтэй аж ахуйн нэгжид үйлчлээд байгаа юм шиг сэтгэгдлийг иргэдэд төрүүлэх нь бий. Гэвч асуудлыг нөгөө өнгөөс харах гэж оролдоё. Шулуухан хэлэхэд, даатгалын компануд иргэдийн халаас руу өнгийх болохоороо байдгаараа бөхийдөг атлаа өгөх дээрээ тулахад гурван өдөр явуулах цаашлаад ажлын 14-21 өдөр хүлээх хэрэг гардаг байна. Энэ асуудал нөхөн олговор дээр байнга тохиолддог. Мөн жолооч машинаа өөр хүнд худалдах тохиолдолд Жолоочийн хариуцлагын даатгал хийлгэсэн газрынхаа заавал төв дээр нь очих шаардлагатай байдаг. Тэр төв дээр нь очиж шилжүүлж, зөрүүгээ авах ёстой. Гэтэл зөрүү нь бодож өгдөггүй байна. Эд зүйл ч ялгаагүй. Орон сууц, хашаа байшин, газар, авто машин зэргээ эдийн засгийн эргэлтэд оруулж, банк болон банк бус санхүүгийн байгууллагын барьцаанд тавьж, тухайн компанийн нэр дээр шилжүүлсэн тохиолдолд өмнөх даатгал хүчингүй болж, тухайн банк болон банк бус байгууллагын харьцдаг даатгалын компанийн даатгалд хамруулах шаардлага тулгардаг. Тодорхой хугацааны дараа өөрийн нэр эргүүлэх шилжүүлэхдээ ч дахиад л даатгал хийлгэх учиртай. Хамгийн гол нь даатгалын зөрүүг даатгалынхан аль болох төлөхгүйг хичээдэг нь нууц биш. Тэр бүү хэл, өмнөх жил нь осол гаргаж, нөхөн төлбөр авсан тохиолдолд дараа жил нь хураамжийн хувина нэмж 58 мянган төгрөг болсон байдаг. Бас нэгж нэмж хэлэх зүйл бол даатгалд хамрагдаж байгаа иргэд гэрээгээ заавал унших ёстой. Үйлдвэрлэлийн буруугаас болж гарсан гэмтэлд /шатсан/ тохиолдолд нөхөн олговор олгохгүй байх магадлал өндөр. Энэ мэтчилэн ямар тохиолдолд мөнгө гаргахгүй байх, ямар салбартай гэрээ хийж, хамтарч ажиллахгүй байгаа тэд сайн мэддэг. Тухайлбал өндөр үнэтэй тоног төхөөрөмж ашигладаг уул уурхайн компанудтай эрсдлийн болоод тоног төхөөрөмжийн гэрээ хийх сонирхол тэдэнд байхгүй. Иймэрхүү маягаар даатгалын компануд ажиллаж, ядарсан иргэдийн халаас руу өнгийж байна даа. Иргэдийн өмнө бөхийж мөнгийг нь авсан шигээ эргүүлээд өгдөг бол ярих зүйл байхгүй ээ. Даанч ...



Гэрэл зурагийг Г.АРИУУЖИН

# ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛИЙН ЭХНИЙ ШАТАНД Х.БАТТУЛГА ТАСАРХАЙ ЯЛЛАА

Б.ТОГТОХ

Монголын ард түмэн өчигдөр Үндсэн хуулиар олгогдсон эрхээ эдэлж Монгол Улсын тав дахь Ерөнхийлөгчөө сонгох сонгуулиа 1984 хэсгийн хороонд өглөө. Монгол Улсын хэмжээнд 1983 хэсгийн хороо байсан ч гадаадад ажиллаж амьдардаг иргэдийг нэг хэсгийн хороо гэж үзжээ. Сонгуулийн насны нийт 1.978.298 сонгогч сонгогчийн саналын хуудсанд бичүүлснээс 1.318.511 сонгогч саналаа өгчээ. Монгол түмний эв нэгдлийн бэлэг тэмдэг болсон тавдагш Ерөнхийлөгчөө сонгох сонгуульд нийт 64.5 хувьтай байсныг СЕХ-ноос эцэслэн мэдэгдсэн юм. Гэвч өрсөлдөгчид нь сонгууль өгсөн иргэдийн 50-1 хувийн саналыг авч чадаагүй учраас Ерөнхийлөгчийн сонгуулийн санал хураалт дахин явагдахаар боллоо. СЕХ болон АН-ын зүгээс сонгуулийн дүнг хүлээн зөвшөөрч буйгаа мэдэгдсэн

юм. Ингэснээр СЕХ 14 хоногийн дотор дараагийн сонгуулийн зарлахаар болсныг СЕХ-ны дарга Ч.Содномцэрэн мэдэгдлээ. Ингэснээр өнөөгийн Ардчилсан Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж ес дэх удаагийн наадмаа нээх ховор хувь тавилан тохиож мэдэх нь ээ. АН-аас нэр дэвшигч Х.Баттулга 01.00 цагийн байдлаар нийт сонгогчдын 39 хувийн санал буюу 504.315 хүний санал авсан бол нэр дэвшигч С.Ганбаатар 31 хувийн санал буюу 404.186 сонгогч түүнд саналаа өгчээ. Харин МАН-аас нэр дэвшигч М.Энхболд нийт сонгогчдын 30 хувь буюу 401.689 сонгогчийн саналыг авчээ. Гэвч энэ бол эцсийн мэдээлэл биш. Өмнө хэлсэнчлэн 1983 хэсгийн хорооноос 1868 хэсгийн хорооны мэдээлэл 01.00 цагийн байдлаар ирээд байсан учраас сонгуулийн дүн мэдээ өөрчлөгдөх магадлал тэр хэрээр нэмэгдэх нь тодорхой байв. СЕХ эцсийн дүн мэдээг өнөөдөр өглөө мэдээлнэ

хэмээн мэдэгдсэн билээ. Өөрөөр хэлбэл, зарим хэсгийн хороодын дүн мэдээг зарлах боломжгүй утсаар авч байгааг Ч.Содномцэрэн дарга онцолсон учраас эцсийн дүн мэдээг уншигч авхай та өнөөдөр сонсох нь ээ. Жил жилийн сонгуулиар давтагдаж байдаг сонгууль тойрсон маргаан ч энэ жил давтагдав. Сонгогчийн цагаан хуудсыг худалдаж авах гэсэн улайрал газар авч, улс төрийн гурван нам нэр дэвшигчээ ялуулахын тулд бүх л хүчээ тавьж өрсөлдлөө. Ээлж дараалан мэдээлэл хийж, хууль зөрчсөн, мөнгө тараах гэсэн үйлдлээ ээлж дараалан баримтжуулж цагдаагийн албан хаагчид ёстой л суух завгүй ажиллав. Өчигдрийн байдлаар нийт 700 гаруй зөрчил маргаантай холбоотой дуудлага ирсэн гэдгийг Цагдаагийн Ерөнхий газраас мэдээлсэн юм. Монгол түмний эв нэгдлийн бэлэг тэмдгийг сонгох энэ удаагийн сонгуульд урьд өмнөх сонгуулиас ирц хангалтгүй

...Тэд нэгнээ хэтэрхий их гүтгэн доромжилж, тэр ч байтугай энэ үйлдэлдээ урлаг соёл, спортын оддыг хүртэл хамруулж спортын тамирчин намын гишүүнийг зодсон гэх мэтээр гүтгэн доромжилж байсан нь энэ удаагийн сонгууль урьд өмнөх жилүүдээс хамгийн хар бараан сонгууль боллоо гэх дүгнэлтэд хүргэжээ...

2017 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн санал тооллогын дүн мэдээлэл урьдчилсан байдлаар

НЭР ДЭВШИГЧДИЙН НЭРС			
Аймаг, дүүргийн нэрс	М.Энхболд	Х.Баттулга	С.Ганбаатар
Архангай	12059	12398	14932
Баян-Өлгий	16003	11760	4871
Баянхонгор аймаг	11497	23886	4137
Булган	7554	8279	9940
Говь-Алтай	9426	6458	8019
Говьсүмбэр	2031	2414	2557
Дорноговь	9487	9158	9507
Дорнод	7950	10178	11600
Дундговь	5142	5414	9004
Завхан	12347	11906	6620
Өвөрхангай	16984	13687	13138
Өмнөговь	7238	8087	11484
Сүхбаатар	9382	8712	7784
Сэлэнгэ	15457	14702	15410
Төв	16546	11253	12855
Увс	11485	6986	4952
Ховд	13724	10060	10221
Хөвсгөл	18802	17420	17804
Хэнтий	7756	11169	12103
Дархан-Уул	12565	12427	16351
Орхон	9863	14771	18451
Багахангай	1104	509	349
Хан-Уул дүүрэг	21027	34595	18761
Баянзүрх дүүрэг	37911	67336	43661
Сүхбаатар дүүрэг	18303	29407	15524
Баянгол дүүрэг	25831	48314	21350
Сонгинохайрхан дүүрэг	36268	53978	50022
Багануур дүүрэг	4077	4275	3742
Налайх дүүрэг	4172	5542	6450
Чингэлтэй дүүрэг	17591	31065	
Гадаад улсад байгаа сонгогчид	995	2979	740

болсон. Энэ нь мэдээж гурван намын өрсөлдөгчийн хар пиар, нэгнээ гүтгэх гэсэн явуургүй улс төрөөс ихээхэн шалтгаалж байлаа. Тэд нэгнээ хэтэрхий их гүтгэн доромжилж, тэр ч байтугай энэ үйлдэлдээ урлаг соёл, спортын оддыг хүртэл хамруулж спортын тамирчин намын гишүүнийг зодсон гэх мэтээр гүтгэн доромжилж байсан нь энэ удаагийн сонгууль урьд өмнөх жилүүдээс хамгийн хар бараан сонгууль боллоо гэх дүгнэлтэд хүргэжээ. Энэ удаагийн сонгуулиар сонгогчдын хуруунд тусгай тэмдэглэгээ хийж байгаагаараа онцлогтой болсон. Учир нь 2008 оны сонгуулиас хойш буюу Монгол Улс сонгуулийн автоматжуулсан систем хэрэглэж эхэлснээс хойш бэхэн тэмдэглэгээг сонгуульд ашиглахаа больсон. Энэхүү тэмдэглэгээг хэрэглэснээр сонгогч дахин санал өгөх зэрэг асуудлаас сэргийлэх боломжтой гэж үздэг. Сонгуулийн ерөнхий хороо энэ асуудлыг судалж, тогтоол гарган, нийслэл дэх нийт 403 хэсгийн санал авах байранд саналаа өгсөн иргэдийн хуруунд бэхэн тэмдэглэгээ хийх шийдвэр гаргаснаар нийслэлийн иргэд бэхэн тэмдэглэгээтэй саналаа өглөө. Нэр дэвшигчдийн 21 аймаг, нийслэлийн есөн дүүрэгт ялалт байгуулсан дүн мэдээг урьдчилсан байдлаар хүлээн авна уу.

# СОНГУУЛЬ-2017

# ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛИЙН

Бэлтгэсэн: Б.ӨНӨРТӨГТОХ  
Н.БАТЗАЯА

Өчигдөр Монголын ард түмэн Монгол Улсын тав дахь Ерөнхийлөгчөө сонгох түүхэн сонголтот хийлээ. Хэдийгээр хоёр өдөр амарч, даваа гарагт мөн л амралтын өдөр таарсан байсан ч иргэд өглөөнөөс эхлэн баяр ёслолын байдалтай үндэсний дээд хувцсаа өмсөн Ерөнхийлөгчийн сонгуульд саналаа өгөхөөр очлоо. Жил жилийн сонгуулийн үеэр маргаан мэтгэлцээн өрнөдөг. Тэр ч ёсоор өнөө жилийн сонгууль ч багагүй маргаан мэтгэлцээн дунд өрнөв. Энэ удаагийн сонгуульд парламентад суудалтай улс төрийн гурван хүчин болох АН, МАН, МАХН-ын гурван нэр дэвшигч өрсөлдөв. Тав дахь Ерөнхийлөгчөө сонгох түүхэн сонгуулийн эргэн тойронд ямар үйл явдал өрнөснийг ММ энэ удаад сурвалжлагаар бэлтгэлээ.

## Иргэдийн идэвх сул байна гэв

**13:00 цагт:** СЕХ-ноос Ерөнхийлөгчийн сонгуулийн ирцийн явцыг сэтгүүлчдэд мэдээллээ. Энэ талаархи мэдээллийг СЕХ-ны дарга Ч.Содномцэрэн хүргэсэн бөгөөд иргэдийн идэвх, оролцоо муу байгаа талаар онцлов. СЕХ-ны дарга Ч.Содномцэрэн “Санал авах ажиллагаа хэвийн үргэлжилж байна. Өмнөх сонгуулийн ирцийн мэдээг 10:00 цагт авсан учраас харьцуулахад төвөгтэй. Гэхдээ өмнөх сонгуультай харьцуулахад явц удаашралтай байна. 2013 оны сонгуулийн ирц нэг цагт найм орчим хувь байсан бол одоо нэг цагт дөрөв гаруй хувьтай байна. Сонгогчдын идэвх тааруу байна” гэв. Үүнтэй холбогдуулан СЕХ-оос 12:00 цагийн ирцийг бүрдүүлж саналаа өгсөн иргэдэд талархал илэрхийлэхийн зэрэгцээ сонгуульд идэвхтэй оролцохыг уриаллаа. Мөн 12:00 цагийн байдлаар СЕХ-нд автоматжуулсан системтэй холбоотой гомдол, санал иржээ. Энэхүү асуудлыг түргэн шуурхай шийдвэрлэж, холбогдох арга хэмжээ авчээ. Түүнчлэн сонгуультай холбоотой хууль бус үйлдлийн талаархи мэдээлэл ирээгүй гэв.

## Улсын хэмжээнд сонгуулийн ирц 45.57 хувьтай байна

**18:00 цагт:** СЕХ-ны Нарийн бичгийн дарга Ц.Болдсайхан Ерөнхийлөгчийн сонгуулийн ирцийн мэдээллийг хүргэв. Тэрбээр “Санал авах ажиллагаа хэвийн үргэлжилж байна. 17:00 цагийн байдлаар нийслэлийн ирцдийн дүн мэдээлэл төвлөсөн цагаасаа удаж байгаа талаар тайлбарлав. Тэрбээр “Ирцийн дүн мэдээллийг бид утсаар авч байна. автоматжуулсан системийн дагуу дүнгээ гаргаж авсаны дараа ажиглагч нарт дүнгээ хэвлэн онлайнаар мэдээлж байна. Мөн ирцийн мэдээг аймаг, дүүргээг нэгтгээд СЕХ-нд мэдээлж байгаа. Үүнээс болж удаж байна” гэлээ. 22:00 цагийн байдлаар иргэд сонгуульдаа 66.54 хувьтай оролцжээ. Мөн зарим сүлжээгүй аймгуудаас нэгдсэн дүн ирээгүй учраас өнөөдөр нэгдсэн дүнг нягталж, албан ёсоор мэдэгдэх гэнэ. Мэдээллийн үеэр СЕХ-ны дарга Ч.Содномцэрэн “Дахин сонгууль болохгүй. Харин дахин санал хураалт гэж бий. Хуульд нэр дэвшигчдийн хэн нь ч олонхийн саналыг аваагүй бол дахин санал хураалт явуула. Олонхийн санал гэдэг бол 50 хувь дээр нэмэх нь нэг санал. Энэ санал хураалтын 14 хоногийн хугацаанд зохион байгуулна” гэлээ.

## Ч.Содномцэрэн: Сонгуулийн нэгдсэн дүнг нягталж, дахин мэдээллэнэ

**23:00 цагт:** Ерөнхийлөгчийн сонгуулийн санал хураалт 22:00 цагт дуусч, СЕХ-оос 22:00 цагийн байдлаарх ирцийн мэдээлэл хийлээ. Мэдээллийн эхэнд СЕХ-ны дарга Ч.Содномцэрэн сонгуулийн ирцийн дүн мэдээлэл төвлөсөн цагаасаа удаж байгаа талаар тайлбарлав. Тэрбээр “Ирцийн дүн мэдээллийг бид утсаар авч байна. автоматжуулсан системийн дагуу дүнгээ гаргаж авсаны дараа ажиглагч нарт дүнгээ хэвлэн онлайнаар мэдээлж байна. Мөн ирцийн мэдээг аймаг, дүүргээг нэгтгээд СЕХ-нд мэдээлж байгаа. Үүнээс болж удаж байна” гэлээ. 22:00 цагийн байдлаар иргэд сонгуульдаа 66.54 хувьтай оролцжээ. Мөн зарим сүлжээгүй аймгуудаас нэгдсэн дүн ирээгүй учраас өнөөдөр нэгдсэн дүнг нягталж, албан ёсоор мэдэгдэх гэнэ. Мэдээллийн үеэр СЕХ-ны дарга Ч.Содномцэрэн “Дахин сонгууль болохгүй. Харин дахин санал хураалт гэж бий. Хуульд нэр дэвшигчдийн хэн нь ч олонхийн саналыг аваагүй бол дахин санал хураалт явуула. Олонхийн санал гэдэг бол 50 хувь дээр нэмэх нь нэг санал. Энэ санал хураалтын 14 хоногийн хугацаанд зохион байгуулна” гэлээ.

## Төрийн гурван өндөрлөг, нэр дэвшигч юу хэлэв


Монгол Улсын тав дахь Ерөнхийлөгчийн сонгох түүхэн сонголтот хийх энэ өдөр төр засгийн олон хүмүүс саналаа өгч, иргэдээ сонгуульдаа идэвхтэй оролцохыг уриалсан юм. Төрт улсаа дээдэлж үндэсний дээд хувцастайгаа ирэх нэгэн байхад албан ёсны үйл явдал хэмээн үзэж костюм зангиагаар гангарах хүмүүс ч тэдэн дунд олон байсан юм. Дараагийн Ерөнхийлөгч тангараг өргөснөөр бүрэн эрх нь дуусах Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж, Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат, Хотын дарга Су.Батболд зэрэг албаны хүмүүсээс гадна Төрийн тэргүүний сонгуульд өрсөлдөж буй гурван нэр дэвшигчид саналаа өгч, ямар байр суурь илэрхийлснийг тоймлон хүргэв.

## М.Энхболд: Эвтэй сайхан сонгууль болоосой

**11:40 цагт:** Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд МАН-аас өрсөлдөж буй нэр дэвшигч М.Энхболд 23 дугаар сургуульд байрлах Чингэлтэй дүүргийн 1937 дугаар хэсгийн санал авах байранд саналаа өглөө. Тэрбээр саналаа өгснийхөө дараа “Монголчууд төрийнхөө сонгуулийг хүндэтгэдэг, баяр ёслолын байдалтайгаар мориныхоо дэлийг засаж, гоёлын



Эвтэй Монголын төлөө М.Энхболдод манай гэр бүл саналаа өглөө..



хувцсаа өмсч саналаа өгдөг уламжлалтай ард түмэн. Би энэ удаагийн сонгуульд ард түмэн минь идэвхтэй оролцож, саналаа өгөөрэй хэмээн уриалж байна. Энэ сонгууль эвтэй, сайхан болоосой. Сонгуулийг зохион байгуулж байгаа 20 гаруй мянган ажилтанд бас ажлын амжилт хүсье” гэв.

## С.Ганбаатар: Монголын минь заяа их

**11:40:** МАХН-аас Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигч С.Ганбаатар БЗД-ийн 1709 дүгээр санал авах байранд очиж саналаа өглөө. Тэрбээр саналаа өгснийхөө дараа “Эрхэм хүндэт ард иргэд ахан дүүсээ. Ерөнхийлөгчийг шууд ард түмнээс сонгодог нь төрийн дээр сандалтайсан намуудыг сахилга баттай байлгадаг цорын ганц тогтолцоо билээ. Монголын улс төрд сахилга бат хамгийн хэрэгтэй байгаа. Ерөнхийлөгч сахилга батыг сахиулж байж, ард иргэд тайван амгалан байх болно. Би иргэдтэйгээ байгуулсан гэрээгээ 100 хувь биелүүлнэ. Монголын минь заяа их. Баярлалаа” гэлээ.

## Х.Баттулга: Саналаа өгөөгүй үлдсэнийг нь уриалах гэж зориуд оройтож ирлээ

**20:40 цагт:** АН-аас Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигч Халтмаагийн Баттулга өөрийн охин Б.Намууны хамт Ерөнхийлөгчийн сонгуульд саналаа өгөхөөр Баянзүрх дүүргийн Сансарын 48 дугаар сургуульд байрлах 1655 дугаар хэсгийн хороонд ирж саналаа өглөө. Тэрбээр, саналаа өгсний дараа “2017 оны Ерөнхийлөгчийг сонгох сонгууль дуусах дөхөж байна. Хоёр сая гаруй иргэн Монгол орон даяар сонгуулиа өгөх юм байна. Иргэд маань идэвхтэй оролцоорой гэж уриалж байна. Нар нэлээд буурсан учраас одоо саналаа өгөөгүй залуусаа ирж өгөөрэй гэж уриалах гэсэн үгднээс оройн цагаар ирсэн юм. Н.Алтанхуяг дарга намайг дэмжээд үг хэлсэн. Миний эсрэг санал өгөхгүй. Ийм цуурхлуудыг манайхан жаахан цензуртэй хүлээж аваарай. Н.Тувшинбаяр аварга хүн зодох хүн биш. Тэнд ажилтай явж байгаа хүн” гэв.

## Ц.Элбэгдорж: Сонгуулиа амжилттай хийгээд сайхан наадамлаа

**11:45 цагт:** Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж, гэргий Х.Болормаагийн хамтаар нийслэлийн Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэр, Орос гуравдугаар сургуульд байрлах буй Ерөнхийлөгчийн сонгуулийн 1851 дүгээр хэсгийн санал авах байранд саналаа өгөв. Саналаа өгсний дараа Ерөнхийлөгч сэтгүүлчдэд хандаж хэлсэн үгэндээ “Та бүхний энэ өдрийн түмэн амгаланг айлтгая. Ард иргэд маань сонгуульдаа идэвхтэй оролцоно гэдэгт итгэж байна. Сонгууль зохион байгуулж байгаа хүмүүс сонгуулиа хуулийн дагуу, иргэдийнхээ чөлөөтэй саналаа илэрхийлэх бололцоог хангаж сайн ажиллана гэдэгт итгэж байна. Сонгуулиа амжилттай хийгээд удахгүй улсын наадам болох гэж байна. Бөхчүүд нь бяргай, морьд нь хурдтай, харваачид нь цэцтэй байхын өлзийтэй ерөөлийг дэвшүүлэе. Сонгуулиа амжилттай хийгээд бүгдээрээ сайхан наадамлаа. Төр улсын маань ажил үйлс урагштай, түмэн олны маань амьдрал амгалан, бүтээл нь улам их байхын өлзийтэй ерөөлийг өргөн дэвшүүлэе” гэлээ.

## Ж.Эрдэнэбат: Эдийн засгийн өөрчлөлтийг баталгаажуулах сонголт байгаасай

**13:00 цагт:** Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат гэргий Ц.Тунгалагийн хамт Баянзүрх дүүргийн 1731 дүгээр хэсгийн

хороонд очиж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгуульд санал өгөв. Тэрбээр санал өгөх үедээ “Монгол Улсын Ерөнхийлөгчийн долоо дахь удаагийн сонгууль болж байна. Өнөөдөр Монгол түмэн тусгаар тогтносон, бүрэн эрхт улсын иргэн гэдгээ илэрхийлэж, тав дахь Ерөнхийлөгчөө сонгоно. Монгол Улсын хөгжлийн төлөө Засгийн газраас олон тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлж байна. Үүний үр дүнд эдийн засагт нааштай өөрчлөлт гарсаар байгаа. Монголын ард түмэн энэхүү өөрчлөлтийг баталгаажуулах сонголт хийнэ гэдэгт эргэлзэхгүй байна. Төр нь түвшин, түмэн олон минь амгалан байх болтугай” хэмээсэн юм.

## Су.Батболд: Үндсэн хуулиар олгосон эрхээ эдэлж сонгуульдаа идэвхтэй оролцоорой

**12:00 цагт:** Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч С.Батболд Хан-Уул дүүргийн 1918 дугаар хэсэг дэх санал авах байранд очиж, саналаа өглөө. Хотын дарга С.Батболд “Төрийн тэргүүнээ сонгох сонгуульд нийслэлийн хэмжээнд 930 гаруй мянган сонгогч санал өгнө. Одоогийн байдлаар 20 гаруй хувь нь өгсөн байна. Иргэдийн маань идэвх сайн байна гэж харж байна. Нийслэлийн төр захиргааны байгууллагууд хуулиар хүлээсэн үүргийнхээ дагуу сонгууль явагдах бүх бэлтгэлийг хангасан” хэмээгээд нийт иргэд, сонгогчдоо Үндсэн хуулиар хүлээсэн эрхээ эдэлж, үүргээ биелүүлэн сонгуульдаа идэвхтэй оролцохыг уриаллаа

## С.Эрдэнэ: Төрийн байгууллагыг увайгүй байдлаар ашиглаж байна

**12:30 цагт:** Монгол Улсын тав дахь Ерөнхийлөгчийг сонгох сонгууль орон даяар явагдаж байна. Тэгвэл УИХ-ын гишүүн, АН-ын дарга С.Эрдэнэ Баянгол дүүргийн 1595 дугаар хэсгийн хороонд очиж, саналаа өгч, иргэний үүргээ биелүүллээ. Тэрбээр саналаа өгснийхөө дараа иргэдэд хандаж “Өнөөдөр монголчууд төрийн тэргүүнээ сонгох саналаа өгч байна. Миний саналаа өгсөн хэсгийн хороон дээр гэхэд үдээс өмнөх байдлаар 30 орчим хувьтай байгаа гэсэн мэдээлэл өглөө. Энэ бол иргэд, сонгогчдын оролцоо сайн байна гэсэн үг гэж харж байна. Цагдаагийн байгууллага улстөржсөн үйл ажиллагааг маш их явууллаа. Монголын улс төрийн түүхэнд байгаагүй сонин үйл явдлууд болж байна. Нэг нам нөгөө намынхаа санхүүжилтийг эрх мэдлээрээ далайлган, цагдаагаар дээрэмдүүлдэг явдал гардаг юм байна. Өнөөгийн эрх баригчид төрийн байгууллагыг сонгуульд эрээ цээргүй, увайгүй байдлаар ашиглаж байгаа” хэмээлээ.

## Сонгууль тойрсон маргаан эрчимжиж, намууд нэг нэгнээ буруутгав

Ерөнхийлөгчийн сонгуулийн санал хураалт явагдаж байсан цаг үед улс төрийн намуудын дунд багагүй маргаан мэтгэлцээн өрнөв. Нөгөөтэйгүүр, саналын хуудасны зургаа олон нийтэд ил тод харуулж Сонгуулийн хуулийн ноцтой зөрчсөн, мөнгө тараасан, цагаан хуудсыг худалдаж авахыг санаархсан үйлдэл ч цөөнгүй гарлаа. Ингээд СЕХ-ны албан ёсны мэдээллээс гадна улс төрийн намууд болон улстөрчид, сонгууль тойрсон ямар маргаан мэтгэлцээнтэй асуудал өрнөснийг уншигч таньд тоймлон хүргэв.

# СОНГУУЛЬ-2017

# ЭРГЭН ТОЙРОНД...



түүхэнд хамгийн хар сонгууль болж байна” гэв.

## Э.Бат-Үүл: Үндсэн хууль зөрчсөн сонгууль болвол тэмцэнэ

**16.00 цаг:** АН-ын сонгуулийн штабаас сэтгүүлчдэд хандаж мэдээлэл хийлээ. Мэдээллийг АН-ын гишүүн Э.Бат-Үүл өгөв. Тэрбээр “Хан-Уул дүүргийн Шувуун фабрик, Өлзийт хорооллын сонгуулийн үйл ажиллагаатай танилцлаа. Сонгуулийн хуулийг зөрчиж, хууль бус үйлдэл гаргасан мэдээлэл цөөнгүй сонсогдлоо. Маш их гомдол саналууд ирж байна. Ер нь санал хураалтад хар зах ажиллаж байна. Хууль бус үйлдэл хэрээс хэтэртээ. Үндсэн хуулийг хамгаалах тангарагтай төрийн албан хаагчид үүнийг зогсоох талаар арга хэмжээ авах ёстой. Гэтэл зарим төрийн албан хаагчид хууль бус үйлдэл холбогдсон тухай мэдээлэл ирсэн. Тэдэнд анхааруулахад энэ бол Эрүүгийн хуулийг зөрчсөн маш хүнд гэмт хэрэг. Энэ бүгд холбогдох эзэнтэйгээ бүртгэгдэж байгаа. Төрийн албан хаагчид өөрсдийгөө хариуцлагад унагахгүйг хичээх хэрэгтэй. Сонгуулийг хууль зөрчиж явуулдаг, Засгийн эрхийг хууль зөрчиж авдаг байдлыг таслан зогсоох хэрэгтэй. Шударга сонгуультай болохын төлөө ард түмэн, иргэний нийгмийн байгууллагуудыг фронт болон тэмцэхийн уриалж байна. Үндсэн хуулийг зөрчсөн сонгууль явагдвал тэмцэх болно. Үүнийг би хариуцлагатайгаар хэлнэ” гэв.

## Д.Амарбаясгалан: АН зориудаар худал мэдээлэл түгээлээ

**16.40 цаг:** МАН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Д.Амарбаясгалан СЕХ-ны талаар болон бусад цаг үеийн асуудлаар мэдээлэл хийсэн юм. Тэрбээр, “СЕХ аль нэг талд ажилладаггүй. Энэ хорооны дарга Ч.Содномцэрэнг АН өөрсдөө томилсон. 2016 оны УИХ-ын сонгууль болон орон нутгийн сонгуулийг зохион байгуулсан хүн. Хоёрдугаарт, иргэний бүртгэлтэй холбоотой АН-аас хийсэн гүтгэлэгтэй холбогдуулан тайлбар хиймээр байна. Ижил нэртэй нэг хүнд хоёр үнэмлэх байгаа, нэг хүний хагя хоёр өөр газар гарч байгаа гэж мэт АН-ын хийсэн мэдэгдлээс үүдэж төрийн байгууллагаас мэдээлэл авлаа. Гэтэл тийм зүйл алга. Улсын бүртгэлээс бидэнд өгсөн мэдээллээр тийм асуудал алга. Нэг хүн хоёр иргэний үнэмлэхтэй байгаа асуухад нэг хүн иргэний үнэмлэхээ солиулах гэсэн юм билээ. Мөн УИХ-ын гишүүн асан Ц.Оюунгэрэл зориуд зохион байгуулалттай худлаа мэдээлэл цацлаа. Тодруулбал, иргэдийн саналыг нууцлах үүднээс СЕХ-ноос хийсэн хавтасыг манай нэр дэвшигч М.Энхболдод саналаа өгсөн эсэхийг харах зорилготой хийсэн гэсэн мэдээлэл хийж байна. Гэтэл иргэд хавтастайгаа хамт уншуулж цахим машин гацаах гэсэн тохиолдол гарсан учраас дээд хэсгийг нь нугалчихсан юм билээ. Цаашаа машин руу орохгүй байх гэж ийм үйлдэл хийсэн гэж тайлбарлаж байна. Гэтэл төрийн албан хаагчдыг хэнд санал өгөх гэснийг харах гэсэн үйлдэл хэмээн гүтгэлээ” гэв. Харин АН-ын зүгээс иргэдийн хуруунд тэмдэглэгээ хийхийг шаардаж, улмаар нийслэлийн хэмжээнд хуруунд тэмдэглэгээ хийж байгаа билээ. Гэтэл үүнийг утгахад арилж байна гэсэн мэдээллийг мөн л АН-ын штабад ажиллаж байгаа хүмүүс тарааж эхэлсэн аж. Тиймээс Ардын намын генсек Д.Амарбаясгалан гараа гурван ч удаа савандаж утаасан ч арилагагүй гэв.

## М.Оюунчимэг гишүүн хууль зөрчив үү

**16.00 цаг:** МАН-аас УИХ-д нэр дэвшин сонгогдсон М.Оюунчимэг гишүүний сошиал сүлжээнд тавьсан зураг олон нийтийн шүүмжлэлтэй тулгарсан билээ. Тодруулбал, М.Оюунчимэг гишүүн “Манай гэр бүлийнхэн сонголт хийлээ” хэмээгээд өөрийнхөө болон МАН-аас нэр дэвшигч М.Энхболдыг дугуйлсан цаасаа цахим сүлжээнд байршуулсан ч төд удалгүй устгасан юм. Гэсэн ч иргэд түүний үйлдлийг баримтжуулан сошиал сүлжээнд тавьж, түүнд хэрхэн хариуцлага тооцох тухай маргаан мэтгэлцээн өрнөөд амжлаа. Эрхэм гишүүний нэр дэвшигчийг дугуйлсан зургаа сошиал сүлжээнд байршуулсан үйлдэл нь Сонгуулийн тухай хуулийг ноцтой зөрчсөн үйлдэл бөгөөд бусдыг аль нэг нэр дэвшигчийг дэмжих, санал өгөхөд уриалан дуудсан гэх зүйл заалтаар 14 хоног баривчлагдах хуультай юм. Монгол Улс хуультай, төртэй. УИХ-ын гишүүний халдашгүй дархан эрх гэдгээр энэ үйлдлээ хайцаалж болох ч төрийн түшээ хүний хувьд арай л зүй зохисгүй үйлдэл гаргалаа хэмээн олон нийт шүүмжилж буй юм. Мөн эрхэм гишүүнээс гадна маш олон иргэд санал өгсөн хуудсаа олон нийтийн цахим сүлжээнд байршуулж байгаа ноцтой зөрчил өчигдөр гарлаа.

## Ц.Оюунбаатар: МАНАН хууль зөрчлөө

**19.00 цаг:** МАХН-ын дэд дарга Ц.Оюунбаатар нарын хүмүүс хэвлэлийн бага хурал хийлээ. Мэдээллийн эхэнд МАХН-ын дэд дарга Ц.Оюунбаатар “Бид сонгуулийн талаархи зарим асуудлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан ард иргэдэд хүргэхийг хүссэн юм. Сонгуулийн үйл ажиллагаа орон даяар явагдаж байна. Гэхдээ хууль зөрчсөн үйл явдал хавтгайрлаа. Зарим тохиолдолд ноцтой нөхцөл байдлыг ч үүсгэлээ. Эрх баригч МАН болон АН-аас иргэдийн саналыг 20, 50, 100 мянган төгрөгөөр худалдаж авч байна. Цаашид ч өсөх хандлагатай байгаа. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын Үндсэн хуулийн гуравдугаар зүйл заалтыг зөрчиж байна. Бид боллоцооныхоо хэрээр мөрдөж, баримтжуулж байна. Монгол хүн та үндэсний аюулгүй байдлаа битгий худалдаарай гэж уриалъя” гэв.

## Цагдаагийн байгууллага аль нэг талд үйлчлээгүй гэв

**20.00 цаг:** Цагдаагийн ерөнхий газраас сонгуулийн үйл ажиллагаатай холбогдуулан хэвлэлийн бага хурал хийлээ. Хэвлэлийн бага хуралд ЦЕГ-ын тэргүүн дэд дарга П.Батбаатар мэдээлэл хийсэн юм. Тэрбээр “Ерөнхийлөгчийн сонгуультай холбоотойгоор нийт 649 гомдол мэдээлэл

шалгагдаж байна. Эдгээрийн 476 нь Улаанбаатар хотод 176 нь хөдөө орон нутагт гарсан байна. Бид өндөржүүлсэн бэлэн байдал зарлаж бүрэн бүрэлдэхүүнээрээ ажиллаж байна. Улсын хэмжээнд 1983 хэсгийн хороонд ажиллаж байгаа. Мөн сонгуультай холбоотой санал гомдлоос гадна өдөр тутам гардаг гэмт хэргийн дуудлагууд ч ирж байна. Сонгуулийн үйл ажиллагааг хэвийн явуулахад үүрэгтэй оролцож буй цагдаагийн байгууллагын алба хаагчдыг “Нэг талыг бариллаа. Аль нэг улс төрийн хүчинд үйлчиллээ” гэх мэтчилэн янз бүрээр хэлж байна. Өнөөдрийн байдлаар ЦЕГ ямар нэгэн нам эвслийг дэмжсэн нь тогтоогдоогүй. Улсын хэмжээнд шалгагдаж буй мэдээллийг зохих журмын дагуу шийдэн шүүх, прокурорт шилжүүлсэн. Цагдаагийн байгууллага үүргээ хэвийн хэмжээнд гүйцэтгэж байгаа гэж ойлгож болно. Цагдаагийн байгууллага аль нэг нам эвсэлд үйлчлээгүй” гэв.

## Иргэдийн саналыг худалдаж авахыг завджээ

Ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр хууль зөрчсөн хэд хэдэн асуудал гарлаа. Сонгуулийн бүртгэлийн хуудас болон иргэдийн саналыг худалдаж авах, мөнгө тараах зэрэг хууль бус үйлдлүүд олон нийтийн мэдээллийн хэрэгслээр цацагдсан байна. Тухайлбал, Дорнод аймгийн иргэдэд АТМ-аар мөнгө тараах гэж байгаад үйлдэл дээрээ баригдаж буй бичлэг фэйсбүүк, твиттер хуудаст тарсан юм. Бичлэгт хоёр эмэгтэй Дорнод аймгийн Баян-Уул, Хөлөнбуйр, Баянтүмэн, Халхгол, Гурванзагал, Чулуунхороот, Дашбалбар, Матад сумын иргэдэд мөнгө тараахаар завдсан бичлэг олон нийтэд дэлгэгдэв. Мөн Баянгол дүүргийн 1612 дугаар хэсгийн хороонд гадаадаас ирсэн иргэн саналаа өгч чадаагүй гэх гомдол гарчээ. Тэрбээр хурууны хэзэгээ уншуултал өөр хүний зураг нэр гарч ирсэн байна. Тухай үед тус хэсгийн сонгуулийн ахлах зохион байгуулагч дүүргийн сонгуулийн хорооноос чиглэл өгсөн хэмээн ажиглагчийг мэдээлэл хөтлүүлж, зураг авахуулаагүй гэнэ. Уг үйлдэл нь Сонгуулийн тухай хуулийн 108 дугаар заалтыг зөрчсөн үйлдэл юм байна. Түүнчлэн сонгуульд анх удаа саналаа өгч буй иргэдийн саналд нөлөөлөх мессэжийг фэйсбүүк чатаар илгээсэн үйлдэл гарчээ. Тодруулбал, Төв аймгийн унаган хүүхэд байна шүү дээ. Нутгийнхаа хүний төлөө саналаа өгөөрэй гэх мэтчилэн мессэжийг илгээжээ. Энэ мэтчилэн хууль зөрчсөн үйлдэл олон байлаа.

## Ц.Оюунбаатар: СЕХ дүнг будлиантуулдгаа зогсоох хэрэгтэй

**00:15 цаг:** Сонгуулийн үйл явцын талаар МАХН-аас шуурхай мэдээлэл хийж тус сонгуулийн штабын дарга Ц.Оюунбаатар “СЕХ бидэнтэй уулзахгүй байна. Сонгуулийн хэсгийн хороон дээр гарсан талонууд цагаараа хэвлэгдсэн байх ёстой. Цагтаа хэвлэгдээгүй бол луйврын нотолгоо. СЕХ Ерөнхийлөгчийн үе үеийн сонгуулийг будлиантуулдаг байдлаа зогсоох хэрэгтэй. Сонгуулийн дүн гаргах үйл ажиллагаа удааширч чирэгдэж байна. Энэ хугацаанд ноцтой нөхцөл байдал гарч болзошгүйг манай сонгуулийн штаб болон иргэд бухимдаж байна. Энэ асуудлаар СЕХ-ны удирдлагуудтай уулзаж гэсэн боловч уулзахгүй байна. Сүүлийн хэдхэн минутын дотор МАН 10 гаруй мянган саналыг авч байгаа нь сонгуулийг луйвардах байдал явж байна. Сонгуулийн шударга явуулах бүх үйл ажиллагаанд хяналт тавьж тооллогыг ил тод байлгах хэрэгтэй” гэлээ.

## СЕХ-ны ирцийн дүн мэдээлэл

Аймаг, дүүргийн нэр	12:00 цагийн сонгуулийн ирц	17:00 цагийн сонгуулийн ирц	22:00 цагийн сонгуулийн ирц
Архангай	16.5	47.88	65.31
Баян-Өлгий	6.9	42.54	62.42
Баянхонгор аймаг	29.2	57.86	72.56
Булган	22.6	46.89	67.38
Говь-Алтай	26	53.53	66.97
Говьсүмбэр	25.4	46.90	66.81
Дорноговь	24.4	46.05	65.17
Дорнод	20.5	36.96	61.36
Дундговь	22	47.49	67.90
Завхан	25	52.35	68.74
Өвөрхангай	24.5	47.44	63.33
Өмнөговь	27.9	47.51	64.66
Сүхбаатар	30.4	55.39	69.86
Сэлэнгэ	24.5	45.10	62.33
Төв	23.6	47.67	67.36
Увс	22.5	50.22	68.86
Ховд	22.3	52.11	66.20
Хөвсгөл	22.3	46.34	66.17
Хэнтий	23.7	48.41	66.97
Дархан-Уул	22.8	38.96	64.47
Орхон	17.6	37.36	59.15
Хан-Уул дүүрэг	17.6	50.38	70.80
Баянзүрх дүүрэг	18.2	43.10	69.43
Сүхбаатар дүүрэг	20.6	44.25	70.28
Чингэлтэй дүүрэг	19.5	41.13	68.16
Баянгол дүүрэг	19.2	45.15	56.68
Сонгинохайрхан дүүрэг	21.8	43.36	70.79
Багануур дүүрэг	19.7	38.95	64.24
Багахангай дүүрэг	28.7	37.17	71.59
Налайх дүүрэг	18.8	37.86	66.92

## Сонгогчийн нэр давхардсан асуудал байхгүй гэв

**10.00 цаг:** Оюуны өмч, Улсын бүртгэлийн ерөнхий газраас сонгогчдын нэрсийн жагсаалтын талаар мэдээлэл хийлээ. Оюуны өмч, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Р.Содхүү “359.393 сонгогчийн мэдээлэл сонгогчийн нэрсийн жагсаалтад ижил нэртэйгээр бичигдсэн байгаа. Овог нэр нь ижил сонгогчид олон байгаа. Жишээлбэл Ганбаатарын Солонго гэдэг нэртэй хүн 66 байх жишээтэй. Эдгээр иргэдийн нэр давхардаж байгаа хэдий ч регистрийн дугаарууд нь бүгд өөр өөр байна. Нийт сонгогчдын 56 хувийн нэр давхцаж байгаа. Хурууны хээ уншуулаад дараа нь дахин тэмдэглэгээ хийж байгаа учраас давхар санал өгөх ямар ч боломж байхгүй. Өчигдөр орой нас барсан хүнд санал өгөх урилга ирлээ гэсэн мэдээлэл ирсэн. Бид зургаадугаар сарын 15-ны өдрөөр тасалж сонгогчдын жагсаалт гаргасан. Гэтэл өнөөдрийг хүртэл нас барсан иргэд бас байгаа учраас 10 гаруй иргэдэд урилга очсон байна” гэв.

## Б.Цогтгэрэлийг уучлалт гуйхыг шаардлаа

**15.00 цаг:** Сонгуулийн санал хураалт дөнгөж эхлэх үед Булган аймгийн харьяат, Олимпын аварга Н.Түвшинбаяр аймгийнхаа АН-ын дарга н.Ариун-Эрдэнийг зодсон гэх мэдээлэл зохион байгуулалттай тарсан билээ. Тэгвэл энэ асуудлыг Олимпын аварга Н.Түвшинбаяр, аймгийн АН-ын дарга н.Ариун-Эрдэнэ нар үгүйсгэж хамтдаа зогсч байгаад мэдээлэл хийсэн бол Их аварга Д.Дагвадорж мөн мэдэгдэл хийлээ. Тэрбээр, “МАН-ын зүгээс АН-ын дарга н.Ариун-Эрдэнийг Олимпын аварга Н.Түвшинбаяр зодсон гэх мэдээллийг зохион байгуулалттай тараалаа. Ингэж хутган үймүүлж болохгүй ээ. Н.Түвшинбаяр аварга тайлбар хийсэн. Тэд хамтдаа санал өгсөн гэдгээ зарлаж няцаалт хийсэн шүү. Та нарын булхай, долдугаар сарын 1-ний хагарлыг хэн эвлэрүүлж өгснийг санаарай. Булган аймгийн цагдаагийн газар эрх баригчдын талд үйлчилж ийм гүтгэлгээ явуулахаасаа ичээч. Бидэнд эв нэгдлийн бэлэг тэмдэг авч ирсэн хүнээ барж идмээргүй байна. Сонгуулийн санал авахын төлөө ингэж гүтгэх ямар шаардлагатай юм бэ. Цагтаа та нар энэ хүнээр бахархаж, омогшиж үйлж дуулж байснаа санаач. Засгийн газрын сайд атлаа “дарваан хэр” гэх хочтой Б.Цогтгэрэл ийм гүтгэлгээ тараалаа. Та уучлалт гуй” гэв.

## Ц.Оюунгэрэл: Хүний эрхийг ноцтой зөрчиж байна

**15.30 цаг:** СЕХ өнөө жилийн сонгуулиар сонгогчдын саналыг нууцлах үүднээс хавтас бэлтгэсэн. Гэсэн ч энэ нь сонгогчдын сонгох эрхийг хамгаалах бус эсрэгээрээ хэнд өгснийг нь хянах гэсэн зохион байгуулалттай үйл ажиллагаа болж, хүний эрхийг зөрчиж буй талаар УИХ-ын гишүүн асан, хүний эрхийн хуульч Ц.Оюунгэрэл мэдээлэл хийлээ. Тэрбээр, “Би 1920 дугаар хэсэг дээр саналаа өгчихөөд ирлээ. Саналаа өгөх гээд ширээний ард суухад миний саналыг хуудсыг ийм дугтуйнд хийсэн байсан. Гэтэл энэ дугтуй нь дээд хэсгээрээ нугалчихсан. Мөн дороос нь хадчихсан байна лээ. Тэгээд саналын хуудсаа дугтуйнд хийхэд жагсаалтын нэгдүгээрт байгаа нэр дэвшигч М.Энхболдын зураг, дугуйлсан эсэх нь ил харагдаж байхаар байна. Би саналаа өгөхөөс өмнө гурван намын ажиглагч дээр очоод энэ хавтасны зургийг авахыг сануулсан. Мөн нотлох баримт гээд аваад гараад ирлээ. Хэн ийм богино хавтас бэлдсэнийг асуухад СЕХ-ноос ирүүлсэн гэсэн. Олон хүний саналаа нууцаар чөлөөтэй өгөх эрхийг зөрчиж байгаа энэ асуудлыг шалгуулна. Ардчилсан төрийн

# ДЭЛХИЙ

МОНГОЛ ДЭЛХИЙН ХЭВЛЭЛД

# Ерөнхийлөгчийн сонгууль ДЭЛХИЙН СОНОРТ БАЙЛАА



asahi.com:  
Ж.Эрдэнэбатын Засгийн газарт ард түмний тавих дүн болох юм

Японы алдартай өдөр тутмын сонин “Асахи”-гийн цахим хуудаст “Монголын Ерөнхийлөгчийн сонгуулийн гол өрсөлдөөн нэр дэвшигч М.Энхболд, Х.Баттулга нарын хооронд болно” гэсэн гарчиг бүхий мэдээлэл нийтлэгдсэн байлаа. Энэхүү мэдээнд “Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа дуусгавар болж буйтай холбоотойгоор Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийн санал хураалт энэ сарын 26-нд болно. Эрх баригч МАН-аас УИХ-ын дарга 52 настай М.Энхболд, АН-аас Үйлдвэр хөдөө аж ахуйн сайд асан 54 настай Х.Баттулга, МАХН-аас 46 настай С.Ганбаатар нарын гурван эрхэм нэр дэвшигч байгаа ч, М.Энхболд, Х.Баттулга нарын хооронд голлох өрсөлдөөн явагдаж байна. Улмаар энэ сарын 27-ны үүрээр гэхэд санал тооллогын дүн гарч магадгүй байна.

NHK: Ерөнхийлөгчийн сонгуулийн дүн 27-ны өглөө гарч магадгүй

Японы “NHK” агентлагийн Цахим хуудаст Монгол Улсын долоо дахь удаагийн Ерөнхийлөгчийн сонгуулийн талаар мэдээлж байна. Түүнд “Монгол Улсад энэ сарын 26-нд Ерөнхийлөгчийн сонгуулийн санал хураалт болно. Сонгуульд гурван нэр дэвшигч өрсөлдөж байгаа бөгөөд хөрш зэргэлдээ БНХАУ-ын эдийн засгийн өсөлт буурсан, ашигт малтмалын үнэ унасны улмаас эдийн засаг нь хямарч, санхүү, эдийн засгаа дахин сэргээхээр ажиллаж байгаа. Хоёр удаа сонгогдож, нийтдээ найман жил төрийн тэргүүнээр ажилласан өнөөгийн төрийн тэргүүний бүрэн эрхийн хугацаа дуусч буйтай холбогдуулан явуулж буй Ерөнхийлөгчийн сонгуульд УИХ-ын дарга М.Энхболд Монгол ардын намаас нэр дэвшигч буй бол Засгийн газрын сайдаар ажиллаж байсан Х.Баттулга хамгийн том сөрөг хүчин Ардчилсан намаас, УИХ-ын гишүүн асан С.Ганбаатар МАХН-аас тус тус нэр дэвшигч байна.

Нүүрс, эс гэх мэт байгалийн арвин их баялагтай Монгол улс БНХАУ руу хийх экспортынхоо хэмжээг нэмэгдүүлж, 2011 оноос хойш гурван жил дараалан эдийн засгаа хоёр оронтой тоонд хүртэл нь өсгөж чадсан юм. Гэвч, БНХАУ-ын эдийн засгийн өсөлт саарч, уул уурхайн түүхийн эдийн үнэ буурсны нөлөөгөөр Монголын эдийн засаг хямарч, өнгөрсөн жилийн байдлаар эдийн засгийн өсөлт нь нэг хувь хүртлээ буурсан юм. Тиймээс сонгуулийн өрсөлдөөнд эдийн засгийг дахин сэргээх асуудал голлох байр суурийг эзэлж буй бөгөөд эрх баригч МАН-ын нэр дэвшигч М.Энхболд дотоодын үйлдвэрлэлийг хөгжүүлж, гадаадаас хөрөнгө оруулалт татахаа амласан. Харин сөрөг хүчний нэр дэвшигч Х.Баттулга байгалийн баялгийн зөв зохиистой ашиглалтад Засгийн газрын оролцоог бэхжүүлж, экспортыг нэмэгдүүлнэ гэдгээ амлаж байгаа бол МАХН-ны нэр дэвшигч С.Ганбаатар хөдөө аж ахуй, мал аж ахуйг сайжруулж, ажилгүйдлийн эсрэг бодлого явуулна гэдгээ амлаж байна. Санал хураалт өнөөдөр өглөө 08:00 цагаас оройн 23:00 цаг хүртэл үргэлжлэх бөгөөд хамгийн эртдээ гэхэд энэ сарын 27-ны өглөө гэхэд үр дүн нь олон нийтэд ил болох төлөвтэй байна.

Nikkei: Шийдвэрлэх шатны сонгууль явагдах болзошгүй

Эдийн засгийн “nikkei.com” сайтад Японы сэтгүүлч Шюнсүкэ Табэтагийн бичсэн сонгуулийн үр дүн, цаашид гарах үр дагаврын тухай сонирхолтой нийтлэл цацагдсан байлаа. Тэрхүү мэдээлэлд “Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн хоёр дахь удаагийн бүрэн эрхийн хугацаа ирэх сард дуусч байгаа. Үүнтэй холбогдуулан даваа гарагт монголчууд гурван нэр дэвшигчдээс сонголтоо хийн, дараагийн шинэ Ерөнхийлөгчөө сонгоно. Сонгуулийн өрсөлдөөнийг өнөөгийн УИХ-ын дарга, эрх баригч МАН-аас нэр дэвшигч М.Энхболд тэргүүлж байна. Түүнчлэн тэрбээр

...Монголын жүдогийн холбооны Ерөнхийлөгч Х.Баттулга өнгөрөгч пүрэв гарагт хийсэн уулзалтынхаа үеэр “Би Монголын баялгийг гурван сая ард түмэндээ эргүүлэн авчрах болно” гэж хэлжээ. Монгол Улсын Ерөнхийлөгч зэвсэгт хүчний дээд командлагчийн үүрэг гүйцэтгэхээс гадна УИХ-аас гаргасан шийдвэрт хориг тавих эрхтэй...

дэмжигчдийнхээ тоог улам ахиулахыг хичээж байгаа бол өрсөлдөгч АН-ын нэр дэвшигч Х.Баттулга эх оронч залуусын дэмжлэгийг авахыг зорьж байна. Тодруулбал, Монголын жүдогийн холбооны Ерөнхийлөгч Х.Баттулга өнгөрөгч пүрэв гарагт хийсэн уулзалтынхаа үеэр “Би Монголын баялгийг гурван сая ард түмэндээ эргүүлэн авчрах болно” гэж хэлжээ. Монгол Улсын Ерөнхийлөгч зэвсэгт хүчний дээд командлагчийн үүрэг гүйцэтгэхээс гадна УИХ-аас гаргасан шийдвэрт хориг тавих эрхтэй. Өнгөрсөн жилийн парламентын сонгуульд МАН ялалт байгуулсны дараа нэр дэвшигч М.Энхболд Ерөнхий сайд болох ёстой байсан юм. Түүний хувьд энэ удаагийн сонгуульд төсвийн шинэчлэлийн төлөөх “Эв нэгдэл”-ийг онцолж, гадны хөрөнгө оруулалт, эдийн засгийн шинэчлэлтийн талаарх бодлогыг хэрэгжүүлнэ гэдгээ хэлсэн юм.

Эхэндээ тэрбээр сонгуульд ялах нь бараг тодорхой байсан. Гэвч, нийслэлийн албан тушаалыг үнэлэн наймаалцсан гэх авлигын дуулиан гарснаар дэмжигчдийнх нь тоо буурсан билээ. Саяхны олон нийтийн дунд явуулсан санал асуулгын дүнгээс үзвэл М.Энхболд, Х.Баттулга нарын аль аль нь 30 гаруй хувийн санал авсан бол түүний араас С.Ганбаатар 10-20 хувийн санал авахаар байв. М.Энхболдыг ихэвчлэн ахмадууд дэмжих хандлагатай байна. Түүнчлэн, нэр дэвшигч С.Ганбаатар ч, гадаадын байгууллагаас хандив авч буй бичлэг нь олон нийтийн сүлжээгээр цацагдсантай холбоотойгоор “үүлэн дээрээс унасан” юм. Ингэснээр бизнесийн туршлагатай Х.Баттулгыг дэмжигчид нэмэгдсэн. Гэхдээ АН-ын нэр дэвшигч ч цэвэр байсангүй. Түүний талаар ОХУ-тай гүн харилцаатай, хилийн чанадад 898 сая ам.доллар нуусан гэх зэрэг мэдээлэл гарсан. Ямартай

ч, даваа гарагийн сонгуулиар нэр дэвшигчдийн хэн нь ч 50+1 хувийн санал авч чадаагүй тохиолдолд, хамгийн олон хувийн дэмжлэг авсан хоёр нэр дэвшигчийн хооронд шийдвэрлэх шатны санал хураалт болно. Ингэснээр 1993 онд анхны Ерөнхийлөгчийн сонгууль болсноос хойш анх удаагаа тус улсад шийдвэрлэх шатны сонгууль болох юм” гэсэн байв.

Xinhua: Шинэ Ерөнхийлөгч 5.5 тэрбум долларын зарцуулалтад хяналт тавина

Манай урд хөршийн төрийн мэдээллийн “Шинхуа” агентлагийн сайтад “Гурван сая хүн амтай, далайд гарцгүй

Монгол Улсын ард иргэд өнөөдөр шинэ ерөнхийлөгчөө сонгохоор саналаа өгч байна. Энэ удаагийн ерөнхийлөгчийн сонгуульд МАН, АН болон МАХН гэсэн тус улсын гурван гол намаас нэр дэвшигчдийн төлөө 1.978.298 сая сонгогч саналаа өгнө. Сонгуулийн санал хураалт орон даяар өглөөний 7:00 цаг эхэлсэн бөгөөд оройн 10:00 цагт дуусна. Төрийн тэргүүний суудлын төлөө өрсөлдөж буй гурван нэр дэвшигч сонгуулийн кампанит ажлынхаа үеэр улс орныхоо өрийн дарамтыг багасгах харилцан адилгүй арга хэмжээнүүдийг санал болгож байв. Эрх баригч МАН-аас нэр дэвшигч М.Энхболд болон сөрөг хүчний АН-аас нэр дэвшигч Х.Баттулга нарын хооронд гол өрсөлдөөн өрнөх төлөвтэй байна. Шинээр сонгогдсон Ерөнхийлөгч нь Монголын эдийн засгийг тогтвортой болгох зорилгоор ОУВС тэргүүтэй олон улсын банк санхүүгийн байгууллагууд болон хандивлагч орнуудаас олгохоор болсон 5.5 тэрбум долларын зарцуулалтад хяналт тавих юм” гэх мэдээлэл нийтлэгдсэн байлаа.

Reuters: Зарим сонгогчид хоосон хуудас уншуулж байв

Ройтерс агентлагийн сэтгүүлч Терренс Эдвард, Иосеф Кампелл нар доорх нийтлэлийг бичжээ. “Монголчууд даваа гарагийн Ерөнхийлөгчийн сонгуульд Засгийн газраас дэвшүүлсэн эдийн засгийг сэргээх төлөвлөгөө, БНХАУ-ын улс оронд нөлөөлөх нөлөөллийн төлөө саналаа өглөө. Харин зарим нь эсэргүүцээ илэрхийлж хоосон саналын хуудас уншуулж байсан

юм. Чингис хааны төрсөн нутаг гэгдээрээ танигдсан байгалийн баялаг ихтэй Монгол улсын Ерөнхийлөгч болохын төлөө өрсөлдөж буй гурван нэр дэвшигч гурвуулаа сонгуулийн үеэр авлигын хэрэгт нэр холбогдсон. Нийслэл Улаанбаатар хотын санал авах хэсгийн хороонд очин, хоосон хуудас уншуулаад гарч ирсэн 22 настай орчуулагч Хишигжаргал “Би үнэхээр сонгуульдаа оролцон саналаа өгөхийг хүсч байна. Гэхдээ эдгээр гурван нэр дэвшигчийг алиныг нь ч дэмжмээргүй байна. Эцэст нь хэлэхэд, хэрэв хангалттай олон хүн хоосон хуудас уншуулбал, өөр сонгууль болох боломжтой” гэж Ройтерс агентлагт ярьжээ. Гэхдээ ихэнх сонгогчид эрх баригч МАН-ын нэр дэвшигч, хөрөнгө оруулалтад ээлтэй улстөрч М.Энхболд, АН-ын нэр дэвшигч Х.Баттулга нарын хооронд гол өрсөлдөөн болно гэсэн хүлээлттэй байна.

Гэхдээ МАХН-аас нэр дэвшигч С.Ганбаатар хангалттай санал авч чадсан тохиолдолд, хоёр долоо хоногийн дараа шийдвэрлэх шатны санал хураалт болох юм. Улаанбаатар хотын зах хэсгийн сонгуулийн хэсгийн хороонд саналаа өгсөн 66 настай малчин Осоржамын Эрдэнэтүвшин “Миний хувьд хамгийн чухал нь агаарын бохирдол, улс орон, ард түмний амьдралын хөгжил, цэцэглэлт” гэж ярьжээ. Монгол Улс парламентын ардчилалтай. Өнгөрсөн жил шинэ Засгийн газар байгуулагдсан юм. Тиймээс Ерөнхийлөгчийн сонгуульд оролцогчдын санал эдийн засгийн хямралаас улс орноо гэтэлгэх эрх баригч МАН-д тавих ард түмний дүнгийн чухал барометрын үүрэг гүйцэтгэх билээ” гэсэн байв.

Төсөл

## ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

2017 оны 06 дугаар сарын 27-ны өдөр

- Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар нь НХААГ 17/0165 “Автобусны эцсийн буудлын цогцолбор барилга, зам талбайн тохижилтын зураг төсөв /нэг байршилд холбох/ боловсруулах ажлыг хэрэгжүүлэх зорилгоор зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.
- Энэхүү зөвлөх үйлчилгээ нь Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газраас 2017 онд хийгдэх болно.
- Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх нь уг үйлчилгээг гүйцэтгэх чадвартайг нотлох дараахи мэдээллийг ирүүлнэ. Үүнд:
  - Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;
  - Барилга, хот байгуулалтын яамны**
    - 1.2.1 1-10 хүртэл давхар барилга байгууламжийн барилга архитектур, орчны ерөнхий төлөвлөгөө, тохижилт, өндөржилт, барилга бүтээцийн зураг төсөл, барилгын зохион байгуулалтын зураг төсөл
    - 1.2.4 Дотор усан хангамж, ариутгах татуурга, халаалт, салхивч агаар сэлгэлт, хөргөлтийн систем, гадна салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл
    - 1.2.5 Дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамж, гадна салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл /10 кВ хүртэл/
    - Дотор радио холбоо, галын болон бусад дохиололын систем, дохиолол, мэдээллийн байгууламжийн зураг төсөл, хамгаалалтын систем, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологи, компьютер хангамжийн дотоод сүлжээ, гадна салбар шугам сүлжээний зураг төсөл
    - Орон сууц, олон нийт, үйлдвэрийн барилгын болон тоног төхөөрөмжийн хянах, хэмжих хэрэгсэл /КИП/, автоматикийн зураг төсөл тусгай зөвшөөртэй байх, тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар;
    - Сүүлийн 3 жил буюу 2014, 2015, 2016 онуудад хийж гүйцэтгэсэн ижил төстэй ажлын жагсаалт, дэлгэрэнгүй мэдээлэл;
    - Тус ажлыг хийж гүйцэтгэх инженер техникийн ажилтны дэлгэрэнгүй мэдээлэл CV-ийг ирүүлнэ.

Чадварыг нэмэгдүүлж сайжруулах зорилгоор зөвлөхүүд түншлэлийн хэлбэрээр оролцож болно.

Мэдүүлгийг Цахим худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn) хаягаар өөрийн ААН-ийн хувийн нууцлалын кодыг ашиглан нэвтэрч цахим хэлбэр (pdf)-ээр илгээнэ.Цахим систем ашиглан илгээх нийт файлын хэмжээ 100 Mb, нэг файлын хэмжээ 15 Mb байна.


- Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг 2017 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 08:00 цагаас 2017 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 17:00 цаг хүртэл авч болох бөгөөд Цахим Худалдан авах систем (www.tender.gov.mn) -ээр 2017 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 10:00 цагийн дотор ирүүлнэ үү.

**Чингэлтэй дүүрэг, Багатайруу-15, Самбуугийн гудамж, Нийслэлийн Засаг захиргааны 4 дүгээр байр, 10 давхар, Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар, 1011 тоот. Утас: 75757810**

# ФОТО СУРВАЛЖЛАГА



## Ерөнхийлөгчийн сонгууль эрэл зургийн дуранд



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

# ЗАВСАРЛАГА

## ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

### Г.ГАНЧИМЭГ

Манай улсад жилд дунджаар 4200 орчим хорт хавдрын тохиолдол шинээр оношлогдож, 3000 орчим хүн хорт хавдрын улмаас нас барж байна. Хамгийн харамсалтай нь шинээр оношлогдсон хорт хавдрын тохиолдлуудын 75 хувь нь бүрэн эмчлэхэд хүндрэлтэй буюу эцсийн шаг болох гурав, дөрөвдүгээр үедээ орсон байдаг аж. Тиймээс хавдрын эрт үеийн илрүүлэлт, оношлогоо чухал юм. Өнгөрсөн оны байдлаар улсын хэмжээнд 16548 хүн хорт хавдрын улмаас эмчийн хяналтад оржээ.

дэрх нөхцөл байдлыг өөрчлөх, хорт хавдрын өвчлөлийн эсрэг авч хэрэгжүүлэх дараагийн шатны арга хэмжээ нь аймгийн нэгдсэн эмнэлгүүдэд анхан шатны үзлэг шинжилгээнд хамрагдсан, хорт хавдрын сэжигтэй үйлчлүүлэгчийн оношийг тодруулах, нарийн мэргэжлийн тусламж, үйлчилгээг цаг алдахгүй үзүүлэх ажлыг шинэ түвшинд гаргах шаардлага, хэрэгцээ тулгамдсан асуудал болсоор байгаа юм.

Хавдар судлалын үндэсний төв болон "Мэдээлэл холбооны сүлжээ" төрийн өмчит компани хамтран бүх аймгийн төвийг



# Хавдрын алсын зайнаас оношлогоо боллоо

Үүний 54.5 хувь нь хөдөө орон нутагт, 45.5 хувь нь Улаанбаатар хотын иргэд байна.

Аймаг, орон нутгийн эмнэлэгт хавдрын анхан шатны оношлогоог хийдэг. Улаанбаатар хотод ирж бүрэн шинжилгээнд хамрагдаж, өвчний оношийг баталгаажуулахад дунджаар нэг сарын хугацаа зарцуулдаг байна. Хавдрын өвчнийг оношлоход 6-8 төрлийн нарийн мэргэжлийн эмч нар оролцдог бөгөөд аймаг орон нутагт мэргэшсэн эмч нар дутагдалтай байдгаас цаг хугацаа алдах, өвчин хүндрэх зэрэг хүндрэлүүд гардаг. Түүнчлэн хавдрын онош баталгаажсны дараа ч жилд 3-6 удаа Улаанбаатарт ирж, тогтмол үзлэг, оношлогоонд хамрагдан давтан эмчилгээнд ордог юм байна. Энэ нь тухайн өвчтөний сэтгэл санаа, цаг хугацаа, санхүүд нэлээд хүндрэл учруулдаг. Үүнээс гадна Хавдар судлалын үндэсний төвийн ачааллыг эрс нэмэгдүүлдэг юм. Хэдийгээр манай улсад "Хорт хавдраас сэргийлэх, хянах дэд хөтөлбөр", "Хорт хавдраас сэргийлэх, хянах дэд хөтөлбөр", "Хорт хавдраас сэргийлэх, хянах үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө", "Хорт хавдрын эсрэг үндэсний аян", "Элэг бүтэн Монгол" зэрэг хорт хавдрын эсрэг томоохон төсөл хөтөлбөр, арга хэмжээнүүд хэрэгжиж, тодорхой ахиц, үр дүн гарч байгаа ч дээрх байдал тулгамдсан асуудал хэвээр байсаар байна. Тиймээс

холбосон өндөр хурдны шилэн кабелийн сүлжээгээр дамжуулан алсын зайнаас хавдрын оношлогоо, тусламж, үйлчилгээг үзүүлэх цогц системийг нэвтрүүлэх "MOMENT" төслийг эхлүүлж, Хавдар судлалын үндэсний төвд өнгөрсөн долоо хоногийн сүүлчээр нээлтээ хийлээ. Нээтийн ёслолд Эрүүл мэндийн сайд А.Цогцэлэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Ц.Ням-Осор, Хавдар судлалын үндэсний төвийн ерөнхий захирал Ж.Чинбүрэн, "Мэдээлэл холбооны сүлжээ" төрийн өмчит ХХК-ийн гүйцэтгэх захирал Ч.Золбаяр нар оролдов.

Хавдар судлалын үндэсний төвийн ерөнхий захирал Ж.Чинбүрэн "Байгаа дэд бүтцээ ашиглаад хавдрын өвчнийг оношийг шуурхай гаргаж, орон нутагт хүргэх системийг бүрдүүлэхэд "Мэдээлэл харилцаа холбооны сүлжээ" компани асар их дэмжлэг үзүүлж байна. Ингэснээр тухайн өвчтөнийг оношийг олох гэж цаг алдахгүй болж байгаа юм. Нөгөөтэйгүүр, өвчтөн Улаанбаатарт ирж үзүүлэх цаг авч, хүлээдэг хүлээлгийн хугацааг богиносгож өгөх. Орон нутгийн иргэдийн санхүүд учирдаг дарамтыг ч багасгаж буй юм. Нийслэлд ирж оношлогоо, эмчилгээнд орох, амьдрах болон замын зардал гээд багадаа 3-5 сая төгрөгийг нэг хүн зарцуулдаг. Нээлтийн үеэр

бид Завхан, Сүхбаатар аймагтай шууд холбогдож, алсын зайн оношлогоо, зөвлөгөөг өглөө. Сүхбаатар аймгаас элэгний хоргүй хавдартай өвчтөн наашаа ирэх гэж байсныг боллуулаа. Энэ өвчтөний хувьд жилдээ нэг удаа эхо-д харуулж, эмчийнхээ хяналтад эмчилгээ, зөвлөгөөгөө аваад явахад болохоор байна. Тиймээс энэ бол айтхар, хэцүү тогтоолоо биш" гэв.

Орчин үеийн мэдээлэл, харилцаа холбооны технологийн ерөнхий ашиглан олон улсад нэвтэрсэн, манай улсад ч олон жил яригдаж байгаа алсын зайны эмчилгээ оношлогооны арга гэж бий болгох эхний шаг ийнхүү татлаа. "Мэдээлэл холбооны сүлжээ" төрийн өмчит ХХК-ийн гүйцэтгэх захирал Ч.Золбаяр "Бид нийгмийн харилцааны хүрээндээ Хавдар судлалын үндэсний төвтэй хамтран Монгол Улсын бүх аймгийн төвүүдийг холбосон өндөр хурдны шилэн кабелийн сүлжээгээр дамжуулан алсын зайнаас хавдрын оношлогоо, тусламж, үйлчилгээг үзүүлэх цогц системийг нэвтрүүлэх "MOMENT" төслийг хэрэгжүүлж эхэллээ. Энэхүү төслийн эхний шатанд 21 аймгийн нэгдсэн эмнэлгүүдийг холбосон өндөр хурдны шилэн кабелийн сүлжээг байгуулж, шаардагдах төгсгөлийн төхөөрөмжүүдийг суурилуулан Хавдар судлалын үндэсний төвтэй холбож, алсын зайны оношлогоо,

эмчилгээний дэд бүтцийг бүрэн хэмжээнд бий болгож байгаа юм. Ингэснээр хавдрын оношлогоо, тусламж, үйлчилгээнд томоохон дэвшил гарч, цаг хугацаа, зардал хэмнэсэн, түргэн шуурхай эмнэлгийн тусламж үйлчилгээний олон боломж, давуу талуудыг бий болгоно" хэмээв.

Орон нутаг болон аслагдасан дүүргүүдийн өвчтний оношийг эцэслэн баталгаажуулахаар шинжилгээний хариуг биет хэлбэрээр Улаанбаатар хот руу хүргүүлдэг байсан бол төслийн үр дүнд шинжилгээний хариу, рентген зураг, дурагийн болон эхо оношлогооны видео бичлэг, компьютер томографийн зураг зэрэг их багтаамжтай зураг, дүрсэн мэдээллийг өндөр нягтралтайгаар хуугацааны хоцрогдолгүйгээр дамжуулах боломж бүрдэж байна. Хөдөө, орон нутгийн иргэд тухайн аймгийн төвийн нэгдсэн эмнэлэг дээрээ үзлэг, оношлогоонд орох үед Хавдар судлалын үндэсний төвийн эмнэл зүйн өндөр мэргэжлийн зөвлөх эмч нарын баг Улаанбаатар хотоос

хот хоорондын өндөр хурдны өргөн зурвасын сүлжээ ашиглан алсын зайнаас шууд холбогдон газар дээр нь оношилж, зөвлөгөө өгч үйлчилснээр хөдөө, орон нутгийн иргэд хорт хавдрын эрт үеийн оношлогоо, нарийн мэргэжлийн эмчилгээ хийлгэх боломжтой болж, олон арван иргэнийхээ амь насыг аварч, зардал мөнгө хэмнэх юм байна. Үүнээс гадна аймгуудын нэгдсэн эмнэлгүүдэд хавдрын оноштой өвчтөнүүдийн оношлогооны талаарх эмч нарын зөвлөгөөн зохион байгуулах хугацааг эрс багасгаж, 14 хоног тутам алсын зайнаас аймаг, орон нутгийн эмч нар Хавдар судлалын үндэсний төвийн хавдрын чиглэлээр нарийн мэргэшсэн, мэргэжлийн зөвлөх багтай хамтран видео хурал зохион байгуулж, цаг алдалгүй тусламж үйлчилгээ үзүүлэх боломжийг ч бий болгожээ. Цаашид ч сумдын хэмжээнд уг төслийг хэрэгжүүлэхээс гадна бусад төрлийн эрүүл мэндийн оношлогоо, үйлчилгээг алсын зайнаас үзүүлэх боломжтой юм.

Улаанбаатарт:

Маргааш  
Өдөр 33  
Шөнө 20

Нөгөөдөр  
Өдөр 33  
Шөнө 20

Өдрийн зурхай

ЗУНЫ ДУНД УЛААН МОРЬ САР ДӨРВӨН НОГООН МЭНГЭТЭЙ ХӨХӨГЧИН ТАХИА ӨДӨР

Наран ургах шингэх: 04.55-20.55

Үс засуулбал: Бие эрхтний хуч сайжирна



Тухайн өдөр тогой, торь, гахай, хулгана жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг туу нөлөөтэй тул элдэв үйлд хяналгай хандаж, бие эрхийг үүшгэй. Бурханы үйл, хувцас хийхэд сайн. Зүүн нүд татвал хувцас олох, баруун чих цангинавал үзэсгэлэн болох, зүүн нь бол үхэл болсныг сонсох, нохой уливал сонсголттой үг сонсох, тагнай загатнавал гэр афидах, бие татвал 1-2 хүн ирэх, хөл татвал голдол аюул болно. Өдрийн сайн цаг нь хулгана, бар, туулай, морь, хонь, тахиа болно.

## ДУУЛГАХ СОНИН

### ЗҮҮН АЗИЙН өсвөрийн шатарчдын тэмцээнийг "АЛТАН ЖОЛОО" групп ивээн тэмгэлээ

Монгол Улсын Ерөнхий сайдын ивээлд зорион байгуулагдаж буй Зүүн Азийн өсвөрийн шатарчдын аварга шалгаруулах тэмцээн энэ сарын 17-26-ны өдрүүдэд болж өндөрлөө. Тэмцээнийг Монголын шатрын холбоо, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Гадаад харилцааны яам, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Биений тамир, спортын газар хамтран зохион байгуулж, дэмжигч байгууллагаар "Алтан жолоо" групп ажиллаж байгаа аж. Тэмцээний нээлтэд Монгол Улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат, УИХ-ын дэд дарга Я.Санжмятав, МШХ-ын Ерөнхийлөгч Ц.Сайнбаяр, "Алтан жолоо" группын Ерөнхийлөгч В.Энхбаатар болон Монгол, БНСУ, БНХАУ, Япон, Малайз, Индонез, Вьетнам болон Сингапур, Тайвань, Хонконгийн баг тамирчид, дасгалжуулагч, бусад албан төлөөлөгч нар байшцаа.



орондоо анх удаагаа зохион байгуулж байгаад баяртай байна. Манай өсвөрийн шатарчин охин, хөвгүүд дэлхийн тавцанд эх орныхоо нэрийг гарган, тун удахгүй дэлхийн аваргатай болно гэдэгт би итгэж байна. Энэ удаагийн Зүүн Азийн өсвөрийн аварга шалгаруулах тэмцээнд 10 орны нийт 452 тамирчин мэргэн оюунаа сорин өрсөлдөж байна. Манай сайхан эх оронд хүрэлцэн ирсэн эрхэм хүндэт өсвөрийн шатарчид, оюуны олимпын аваргууд, та бүхэндээ Засгийн газрын нэрийн өмнөөс болон хувиасаа спортын өндөр амжилт хүсэж, эрүүл энх, сайн сайхныг ерөө. Монгол оронд тавтай морилно уу" гэлээ. Мөн энэ үеэр Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат эхний нүүдлийг хийж тэмцээнийг эхлүүлсэн юм. Манай улсад анх удаа зохион байгуулагдаж буй энэхүү тэмцээнийг "Алтан жолоо" групп дэмжин ажиллаж байгаа бөгөөд тэмцээний үеэр БСШУ-ны сайд Г.Чулуунбаатар, "Алтан Жолоо" группын Ерөнхийлөгч В.Энхбаатар нар тэмцээний үйл ажиллагаатай танилцаж, "Алтан Жолоо" группын Ерөнхийлөгч В.Энхбаатар өсвөрийн тамирчиддаа амжилт хүслээ.

## Бидэнд тохиолдсон



### Н. Нямдэлгэр



Манай ах бөө юм л даа. Өчигдөр сахиусаа буулгасан юм нөхөр бид 3 хүүхдээ дагуулж очсон юм. Сахиусаа буулгах гээл хэнгэргээ цохисон чинь манай том охин (бнастай) гадаа тоглож байсанаа хамт тоглож байсан хүүхдээ Хөөе бөмбөрөө нүдэх гэж байна орйё хоёулаа гэдэгийн инээд хүрсэн гэж. Тэгээл ахын сахиус нь орж ирээл сууж байсан чинь бас л манай нөгөө хүнд гар энэ одоо жүжиглээд байгаа юм уу гэдэг юм даа хэлэх ч үг олдсонгүй энэ хүүхдүүдийн хэл ам гэж нээрээ...



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН АЖ АХУ СУРГУУЛЬ

## МУБИС-г багш шалгаруулж авна

<p><b>БАГШИЙН СУРГУУЛЬ:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Сурган сэтгэл судлалын багш -1</li> <li>- Хөгжим арга зүйн багш -2</li> </ul> <p><b>БОЛОВСРОЛ СУДАЛАЙН СУРГУУЛЬ:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Сэтгэл судлалын багш -1</li> </ul> <p><b>УРЛАГ, БИЕЙН ТАМИРЫН СУРГУУЛЬ:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Хөгжмийн онолын /гармони/ багш-1</li> <li>- Найрал дууны багш -1</li> <li>- Сагсан бөмбөгийн мэргэжлийн багш-1</li> </ul> <p style="text-align: center;">тус тус шалгаруулж авна.</p>	<p><b>БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- CV монгол хэлээр</li> <li>- Бакалавр, магистр докторын дипломын баталгаажуулсан хуулбар</li> <li>- Төрийн албан хаагчийн анкет</li> <li>- Ажил байдлын тодорхойлолт</li> <li>- Иргэний үнэмлэхний баталгаажуулсан хуулбар</li> <li>- Цээж зураг 3 хувь /3*4/</li> <li>- Нийгмийн даатгалын дэвтэр, эрүүл мэндийн дэвтэрийн хуулбар</li> <li>- Шалгалтын хураамж 20.000 төгрөг тус тус авч ирнэ үү</li> </ul> <p><b>ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА:</b></p> <p>Монгол улсын төрийн болон гадаадын их дээд сургуулиудыг магистр болон түүнээс дээш зэрэгтэй төгссөн, ерөнхий боловсролын сургууль болон их дээд сургуулиудад багшилж байсан туршлагатай, судалгааны арга зүй эзэмшсэн, гадаад хэл (англи, орос, болон бусад), сурган хүмүүжүүлэх ухаан, боловсрол судлалын зохих мэдлэгтэй, мэдээлэл харилцааны технологийн хэрэглээний чадвар эзэмшсэн, багаар ажиллах чадвартай, оюутнуудтай харилцах эвдүйтэй, бүтээлч сэтгэлгээтэй, боловсролын шинэчлэлд нээлттэй, тогтвор суурьшилтай ажиллах, багшийн ёс зүйг сахидаг байх.</p> <p style="text-align: center;"><b>Бүртгэл: 2017 оны 06 дугаар сарын 19-23-ныг дуустал МУБИС-ийн 1-р байрны /хуучнаар А байрны/ 108 тоотод явагдана.</b></p> <p style="text-align: center;"><b>Холбоглох утас: 311547, 99957309 Хөтөлбөрийн нэгдсэн алба</b></p>
---	---

**ШАЛГАЛТ:** 2017 оны 06 дугаар сарын 26-30-ны өдрүүдэд дараах чиглэлээр явагдана.

**Үүнэ:**

- 1 Эхний ярилцлага
- 2 Мэргэжлийн шалгалт
- 3 Гадаад хэл /Англи, орос болон бусад хэл/
- 4 Мэдээлэл харилцаа технологийн хэрэглээний чадвар
- 5 Боловсрол судлалын орчин үеийн асуудлууд
- 6 Нэгдсэн ярилцлага

***Жич:** Тухайн шалгалтандаа тэнцээгүй ажил горилогчийг дараагийн шатны шалгалтад оролцуулахгүй бөгөөд хураамжийг буцаан олгохгүй болохыг анхаарна уу*